

## ЕРӨНХИЙ АГУУЛГА

1. ТАЙЛАНТ ХУГАЦААНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ .....	2
2. ЗАХИРГААНААС ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР	
2.1.КОМПАНИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖЛЫН ТАЛААР .....	3-13
2.2.СУРГАЛТЫН ТАЛААР .....	14-21
2.3.ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ТАЛААР .....	22-26
2.4.АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР .....	27-31
3. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР .....	32-56
4. ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР .....	57-63
5. ТЕХНИК ХЯНАЛТ, ХАБЭА-Н ЧИГЛЭЛЭЭР .....	64-72
5.1.ХАБЭА-Н ТАЛААР	
5.2.ТЕХНИК ХЯНАЛТЫН ТАЛААР.....	73-76
6. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ЭД ХӨРӨНГӨ АШИГЛАЛТ	
6.1. БЭЛЭН МӨНГӨ БОЛОН БЭЛЭН БУС ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЛГЭЭ .....	77-79
6.2. БАРАА МАТЕРИАЛ .....	80-85
6.3. НИЙТ ЗАРДАЛ.....	86-91
6.4. ҮНДСЭН ХӨРӨНГӨ.....	92-93
6.5. АШИГ АЛДАГДАЛ.....	93-94
6.6. АВЛАГА, ӨГЛӨГ .....	95-97
6.7. ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО .....	98
7. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР .....	99-110
7.1.АЖ АХУЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР.....	111-112
7.2.ЦАЙНЫ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР.....	113-114
7.3.АВТО ХҮНД МАШИН МЕХАНИЗМЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР.....	115-116
8. ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР .....	117-131
9. БҮТЭЭЛЧ АЖИЛ .....	132-139
10. ТАЙЛАНТ ОНЫ АЖЛЫН ҮР ДҮН.....	140

## НЭГ. ТАЙЛАНТ ХУГАЦААНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛГО, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт №1

№	Зорилго	Хэрэгжүүлсэн ажил	Биелэлт /%/
1	Хүний нөөцийг дэмжих жил болгох зарлах, сургалтуудыг үе шаттай зохион байгуулах.	Сургалтын төлөвлөгөөний дагуу эрх олгох 5 төрлийн сургалтанд 197 ажилтан, мэргэжил дээшлүүлэх 17 төрлийн сургалтанд 123 ажилтан, нийтийг хамарсан 6 төрлийн сургалтанд 94 ажилтан, нийт 2025 онд 28 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 414 ажилтанг хамруулсан. Ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, боловсон хүчнийг чанаржуулах зорилгоор шуурхай ажиллагааны ажилтнуудад ажлын байран дээрх сургалтыг ИТА нар нийт давхардсан тоогоор 124 удаа зохион байгуулсан байна.	100%
2	Үйлдвэрлэлийн үндсэн болон туслах тоноглолын найдвартай ажиллагааг хангаж 2025 онд 1,157,669 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж, 1,136,369.3 Гкал дулааны эрчим хүч түгээнэ.	2025 онд төлөвлөгөө 1,157,669 Гкал, гүйцэтгэл 1,100,306 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 57,363 Гкал дутуу үйлдвэрлэж төлөвлөгөөний биелэлт 95% байна. 2025 онд 1,136,369 Гкал дулааны эрчим хүч түгээхээр төлөвлөснөөс 1,082,753 Гкал дулааны эрчим хүч түгээсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 53,616 Гкал-аар дутуу түгээж төлөвлөгөөний биелэлт 95.3% байна. Өмнөх оноос дулааны эрчим хүч түгээлтийн төлөвлөгөөг 55,780.1 Гкал-аар илүү түгээсэн байна.	95.3%

## АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН 2025 ОНЫ ЗОРИЛТ, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт №2

№	Зорилт	Хэрэгжүүлсэн ажил	Биелэлт /%/
1	Мэргэжлийн, ажлын байрны, аюулгүй ажиллагааны сургалтуудыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	Сургалтын төлөвлөгөөний дагуу эрх олгох 5 төрлийн сургалтанд 197 ажилтан, мэргэжил дээшлүүлэх 17 төрлийн сургалтанд 123 ажилтан, нийтийг хамарсан 6 төрлийн сургалтанд 94 ажилтан, нийт 2025 онд 28 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 414 ажилтанг хамруулсан. Ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, боловсон хүчнийг чанаржуулах зорилгоор шуурхай ажиллагааны ажилтнуудад ажлын байран дээрх сургалтыг ИТА нар нийт давхардсан тоогоор 124 удаа зохион байгуулсан байна.	100%
2	2025 онд ДҮТ-өөс өгсөн горимыг мөрдөж ажиллах.	ДҮТ ТӨХХК-аас өгсөн сар, өдөр бүрийн горимоор параметрын зөрчилгүй ажилласан.	100%
3	Аваари, осолгүй ажиллах.	Ажлын байранд ажил гүйцэтгэж байхдаа үйлдвэрлэлийн хөнгөн осол гаргаагүй ажилласан байна.	100%
4	ISO45001 стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах	Компанийн журмуудыг тус стандартад нийцүүлэн шинэчилж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан.	100%


## ХОЁР. ЗАХИРГААНААС ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

### 2.1. КОМПАНИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

#### Удирдлага, зохион байгуулалтын бүтэц, ажиллах хүчин

Амгалан дулааны станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар тогтоолоор компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг 219 орон тоотойгоор шинэчлэн батлуулж, мөрдөн ажилласан.

Схем №01



Монгол Улсын Ерөнхий сайдын 01, 04 дүгээр албан даалгавар, Монгол Улсын Засгийн газрын 61 дүгээр тогтоолын 5 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2025 оны А/191 дүгээр тушаалыг үндэслэн, Эрчист Монгол ХХК-ийн 2025 оны 01/151 тоотой өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор тус компани нь Гүйцэтгэх захирлын 2025 оны А/131 дүгээр тушаалаар

“Ажлын байрны чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын байр хасах” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан.

Уг ажлын хэсгийн шинжилгээ, дүгнэлтээр 219 ажлын байрнаас 7 ажлын байрыг хасаж, орон тоог цөөрүүлж 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 212 орон тоотой ажлын байрны жагсаалтыг Гүйцэтгэх захирлын тушаалаар батлан, мөрдөн ажилласан.

Батлагдсан 212 ажлын байрыг нэгж бүрээр дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт №3

№	Хэлтэс, цех	Ажлын байрны орон тоо
1	2	3
1.	Удирдлага	1
2.	Менежер	2
3.	Ерөнхий инженер	1
4.	Захиргаа удирдлагын хэлтэс	7
5.	Хяналтын хэлтэс	5
6.	Үйлдвэрлэлийн бодлого, шуурхай ажиллагааны хэлтэс	9
7.	Санхүү, эдийн засгийн хэлтэс	8
8.	Худалдан авах ажиллагааны хэлтэс	4
9.	Зуухан цех	36
10.	Түлш дамжуулах цех	47
11.	Засварын цех	22
12.	Цахилгаан цех	28
13.	Хими хэсэг	16
14.	Авто хүнд машин механизмын хэсэг	18
15.	Цайны газар	4
16.	Үйлчилгээ, харуул хамгаалалтын хэсэг	4
<b>Нийт</b>		<b>212</b>

### Нийт ажилтнуудын хүйсийн харьцаа

Хүснэгт №4

№	Хүйс	Хүний тоо	Хувь
1	Эрэгтэй	168	77%
2	Эмэгтэй	44	23%
<b>Ажиллаж байгаа нийт хүний тоо</b>		<b>212</b>	<b>100%</b>

### Ажилтнуудын насны ангилал

Хүснэгт №5

№	Насны ангилал	Хүний тоо	Хувиар
1.	21-30 нас	30	14%
2.	31-40 нас	108	51%
3.	41-50 нас	38	18%
4.	51 < дээш нас	36	17%
<b>Ажиллаж байгаа нийт хүний тоо</b>		<b>217</b>	<b>100%</b>

Компанийн нийт ажиллагсдын 108 ажилтан буюу 51% нь 31-40 насны залуучууд ажиллаж байна.


### Ажилтнуудын боловсролын түвшин

Хүснэгт №6

№	Боловсролын түвшин	Хүний тоо	Хувиар
1.	Бага, бүрэн бус дунд	20 хүн	9,4%
2.	Бүрэн дунд	51 хүн	24%
3.	Тусгай дунд	12 хүн	5,6%
4.	Дээд	129 хүн	61%
<b>Ажиллаж байгаа нийт хүний тоо</b>		<b>212</b>	<b>100%</b>

Компанийн нийт ажилтнуудын 59,6 хувь нь дээд боловсролтой байна.

График №01



### Нийт ажилтнуудын боловсролын мэргэшлийн зэрэг

Нийт дээд боловсрол эзэмшсэн 129 ажилтнуудаас 56 ажилтан буюу 43,4% нь эрчим хүчний чиглэлээр мэргэжил эзэмшсэн байна.


## Хүснэгт №7

№	Боловсролын түвшин	Хүний тоо
1.	Монгол Улсын Зөвлөх инженер	3
2.	Мэргэшсэн нягтлан бодогч	1
3.	Мэргэшсэн аудитор	1
4.	Мэргэшсэн инженер	15 хүн
<b>Нийт</b>		<b>20</b>

Гүйцэтгэх захирлын тушаалаар Монгол Улсын Зөвлөх 3 инженерт үндсэн цалингийн 20%, Мэргэшсэн 15 инженерт үндсэн цалингийн 15%, Мэргэшсэн 1 нягтлан бодогчид үндсэн цалингийн 15%-ийн нэмэгдлийг сар бүр олгуулсан.

## Нийт ажилтнуудын эзэмшсэн мэргэжил

График №2



Нийт дээд боловсрол эзэмшсэн 129 ажилтнуудаас 56 ажилтан буюу 43,4% нь эрчим хүчний чиглэлээр мэргэжил эзэмшсэн байна.

## Эрчим хүчний салбарт ажилласан удаан жилийн нэмэгдэлийн талаар

Эрчим хүчний салбарт ажилласан удаан жилийн нэмэгдэлийг 2025 оны Б/30 дугаар тушаалаар давхардсан тоогоор 209 ажилтанд олгуулсан байна. Үүнд:

## Хүснэгт №8

№	Ажилласан жил	Үүнд				Нийт
		Ээлжийн		Ээлжийн бус		
		Нэмэгдэл хувь, хэмжээ	Нэмэгдэлд хамрагдсан ажиллагсдын тоо	Нэмэгдэл хувь, хэмжээ	Нэмэгдэлд хамрагдсан ажиллагсдын тоо	
1	2-4 жил хүртэл	15%	30 хүн	10%	10 хүн	40 хүн
2	4-7 жил хүртэл	25%	21 хүн	20%	5 хүн	26 хүн
3	7-10 жил хүртэл	30%	74 хүн	25%	11 хүн	85 хүн
4	10-15 жил хүртэл	35%	29 хүн	30%	2 хүн	31 хүн
5	15 ба түүнээс дээш жил	40%	17 хүн	35%	10 хүн	27 хүн
Нийт			171		38	
Нийт					209	

**Ажил, албан тушаал хавсран гүйцэтгэж буй ажилтнуудын жагсаалт**

Тайлант хугацаанд Гүйцэтгэх захирлын тушаалаар нийт 10 ажилтанд ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлж, нэмэгдэл хөлс олгосон байна.

## Хүснэгт №09

№	Хавсран гүйцэтгэж буй ажилтны нэр	Хавсран гүйцэтгэж буй ажилтны ажлын байрны нэр	Хавсран гүйцэтгэж буй ажил, албан тушаал
1.	Э.Мөнгөнцэцэг	Эдийн засагч	Өмч хөрөнгө хамгаалах байнгын зөвлөлийн Нарийн бичгийн ажил үүрэг
2.	Д.Долгормаа	Эдийн засагч	Өмч хөрөнгө хамгаалах байнгын зөвлөлийн Нарийн бичгийн ажил үүрэг
3.	Г.Уянга	Хангамжийн мэргэжилтэн	Өмч хөрөнгө хамгаалах байнгын зөвлөлийн Нарийн бичгийн ажил үүрэг
4.	Б.Батцоож	Гэрээ, борлуулалтын инженер	Нууцын ажилтан
5.	Г.Саруул	Хуулийн мэргэжилтэн	ХАСХОМ-ийн ЭБАТушаалтан
6.	Б.Буянт	Захирлын туслах	Архивын ажилтан
7.	Т.Ичинхорлоо	Хүний нөөцийн менежер	Сургалт судалгааны мэргэжилтэн
8.	Э.Одбаяр	РХАМонтёр	РХАИнженер
9.	Э.Наранбаатар	Бараа, материалын нягтлан бодогч	СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогчийн ажил үүргийг түр орлон гүйцэтгэгч
10.	Г.Баярчимэг	Бараа, материалын нярав	Үндсэн хөрөнгийн нягтлан бодогч

### Ажилтнуудын шилжилт, хөдөлгөөн

Тайлант онд ажилтнууд өндөр цалинтай байгууллагад шилжин ажиллах, гадаад улсад гэрээгээр ажиллах зорилгоор ажлаас олноор гарч удаа дараа ажиллах хүчний дутагдалд оруулж байлаа. Тайлант хугацаанд 39 ажилтан ажлаас чөлөөлөгдөж, 45 иргэн ажилд орж, 32 ажилтан хэсэг цехэд шилжин ажиллаж, байна.

Хүснэгт №10

№	Шинээр ажилд орсон		Өөр ажил, албан тушаалд шилжин ажилласан	Ажлаас чөлөөлөгдсөн			Сахилгын шийтгэл авагдсан		
	Хугацаагүй хөдөлмөрийн гэрээ байгуулсан	Хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулсан		Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн	Тэтгэвэрт	Гэрээний хугацаа дууссан	Сануулах арга хэмжээ	1-3 сарын цалингийн 20%-ийг хасах	Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нуцлагдсан
1	2	43	32	29	5	5	11	5	7

График №3




**2023-2025 онд үйлдвэрлэлийн ажилтнуудын өөрийн хүсэлтээр  
ажлаас чөлөөлөгдсөн судалгаа**

Хүснэгт №11

№	Огноо	Үйлдвэрлэлийн нэгжүүдийн ажилтны нийт тоо	Үйлдвэрлэлийн нэгжүүдээс ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын тоо	Үйлдвэрлэлийн нэгжүүдээс ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын эзлэх хувь	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнууд				
					Мэргэжлийн зэрэг			ИТА	Бусад техникийн ажилтан
					III	IV	V		
1	2023 оны XII/31	140	32	23%	10	4	6	7	5
2	2024 оны XII/31	143	53	37%	17	9	7	12	8
3	2025 оны XII/31	158	22	14%	8	2	-	3	9

График №4



**Чөлөө олголтын талаар**

Ажилтнуудын хүсэлт болон нэгжийн удирдлагын саналыг харгалзан Хөдөлмөрийн дотоод журмын дагуу нийт 19 ажилтанд 1048 цагийн хувийн олговортой чөлөө, 30 ажилтанд 1,664 цагийн хувийн олговоргүй чөлөөг тус тус тайлант хугацаанд олгуулсан. Үүнд:

Хүснэгт №12

№	Хувийн олговортой чөлөө		Хувийн олговоргүй чөлөө	
	Хүн	цаг	Хүн	цаг
1	9	600	60	2416
Нийт			69 хүн	3016 цаг

### Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн талаар

Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор **264 ажилтанд 82,563,200** төгрөгийн нийгмийн халамжийн тусламж, тэтгэмж, урамшууллыг өргөдөл, хүсэлтээр Хамтын гэрээний дагуу Гүйцэтгэх захирлын тушаалаар олгуулсан. Үүнд:

Хүснэгт №13

№	Нийгмийн халамжийн төрөл /Давхардсан тоогоор 264 ажилтанд 82,563,200 төг/	Хамрагдсан ажилтны тоо	Олгосон тусламж /төгрөгөөр/
1	Ажилтнуудын төрсөн эцэг эх, эхнэр, нөхөр, хүүхэд хүнд өвчний улмаас эмчилгээний зардалд олгосон буцалтгүй тусламж. /ХГ 6.11/	14	35,059,200
2	Өрх толгойлсон эцэг, эхэд олгосон тэтгэмж. /ХГ 6.18/	7	6,652,800
3	Хүүхэд асрах чөлөөтэй эхчүүдэд олгосон тэтгэмж./ХГ 6.13/	7	6,180,000
4	Ажилтнуудын төрсөн эцэг эх, эхнэр, нөхөр, хүүхэд нас барж уй гашуу тохиолдоход олгосон буцалтгүй тусламж. /ХГ 6.5/	4	10,771,200
5	Байгалийн гамшигт өртөж хохирсон ажилтанд олгох тусламж. /ХГ 6.10/	1	500,000
6	Рашаан сувилалын хөнгөлөлт. /ХГ 6.8/	6	900,000
7	Дулааны үнийн хөнгөлөлт /ХГ 6.5/	225	22,500,000
<b>Нийт ажилтны тоо /давхардсан тоо/</b>		<b>264</b>	<b>82,563,200</b>

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2025-2030 оны “ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ”, “ХҮНИЙ НӨӨЦИЙН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТ”-ийг тус тус боловсруулж, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан.

Зураг №1



## Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах тухай хуулийг сурталчлах талаар

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх”-ийн тухай хуулийг сурталчилах зорилгоор 5 минут 10 секундын богино хэмжээний монгол хэл дохионы хэлмэрч, орчуулагчийг оролцуулан өөрсдийн нөөц бололцоогоор видео бичлэг хийж, станцын нийт ажилтнуудад сурталчилж, компанийн веб сайт, социал сувгуудаар сурталчилсан.

Зураг №2



Видео бичлэг: <https://www.facebook.com/share/v/1A7HjEUNqB/>

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх”-ийн тухай хуулийг сурталчилах зорилгоор хуулийн товчлолыг 4-н цех, 4-н хэлтсийн мэдээллийн самбарт нийтэд мэдээлж байршуулсан.

Зураг №3



Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3 дахь хэсэгт заасны дагуу 2025 оны 01 дүгээр сараас 2025 оны 12 дугаар сарыг дуусах хүртэлх 12 сарын хугацааны ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох нийт 28,908,000 төгрөгийг сар бүр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд бүрэн төлсөн.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр төлсөн  
талаарх 2025 оны судалгаа**

Хүснэгт №14

Он	Сар	Ажиллавал зохих ажилтны тоо	Ажиллавал зохих хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо	Ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо	Ажиллуулаагүй ХБИ-ний тоо	Нийт төлөх төлбөр	Тайлбар
2025	1	217	9	4	5	3,300,000	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 27 дугаар тогтоол, АДС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны Б/06 дугаар тушаалын дагуу ажлын байрны орон тоог 217-оор шинэчлэн тогтоосон. Мөн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 03 дугаар тогтоолын дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 792,000 төгрөгөөр тооцсон болно.
	2	217	9	4	5	3,300,000	
	3	217	9	4	5	3,300,000	
	4	217	9	7	2	1,584,000	
	5	217	9	7	2	1,584,000	
	6	217	9	7	2	1,584,000	
	7	217	9	6	3	2,376,000	
	8	217	9	6	3	2,376,000	
	9	217	9	6	3	2,376,000	
	10	217	9	6	3	2,376,000	
	11	217	9	6	3	2,376,000	
	12	217	9	6	3	2,376,000	
<b>НИЙТ ТӨЛСӨН ТӨЛБӨР</b>						<b>28,908,000</b>	

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1 ажилтанд хамтын гэрээний дагуу эмчилгээний зардалд 2,692,800 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 6 ажилтанд нийт 30 өдрийн хувийн олгортой чөлөө олгосон.

**Жендэрийн эрх тэгш байдлыг хангах** 2025 оны төлөвлөгөөний биелэлтийн дагуу гаргаж Эрчим хүчний яаманд хүргүүлсэн. Мөн ЭХЯ болон Жендэрийн үндэсний хорооноос “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл” сэдэвтэй сургалт зохион байгуулагдсан.



### Шагнал урамшууллын талаар

Тайлант онд дараах шагналын төрөлд тодорхойлолтуудыг явуулж, давхардсан тоогоор 151 ажилтныг шагнасан байна.

Хүснэгт №15

№	Шагналын төрөл	Шагнуулсан ажилтны тоо	Шагнагдсан ажилтны тоо
1	Төрийн болон дээд байгууллага, ТББ-аас олгосон шагнал	Төрийн дээд одон медаль /Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон	1
		Эрчим хүчний тэргүүний ажилтан тэмдэг	9
		Эрчим хүчний яамны “Жуух” бичиг	24
		НЗДТГ-ын “Жуух” бичиг	6
		Нийслэлийн тэргүүний ажилтан “Хүндэт тэмдэг”	5
		МЗХ-ны “Алтан Од” тэмдэг	4
		МЗХ-ны “Монгол тандаа зүтгэе”	4
<b>Нийт</b>			<b>53</b>
2	Байгууллагын шагналаар	Хүндэт дэвтэрт бичигдсэн	1
		Хөдөлмөрийн аварга	1
		Тэргүүний ажилтан	5
<b>Нийт</b>			<b>7</b>
3	Хамтран ажилладаг байгууллагын шагнал	Мөнгөн шагнал	91
<b>Нийт</b>			<b>91</b>
<b>БҮГД</b>			<b>151</b>

## 2.2. СУРГАЛТЫН ТАЛААР

Сургалтын төлөвлөгөөний дагуу 2025 онд 28 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 414 ажилтан хамрагдсаныг дараах хүснэгтээр товчоолон харуулав. Үүнд:

Хүснэгт №16

№	Үзүүлэлт	Сургалтын төрөл	Сургалтанд хамрагдсан ажилтны тоо (Давхардсан тоогоор)
1	Эрх олгох	5	197
2	Мэргэжил дээшлүүлэх сургалт	17	123
3	Нийтийг хамарсан сургалт, зөвлөгөөн	6	94
<b>Дүн</b>		<b>28</b>	<b>414</b>

### Мэргэжлийн зэрэг олгосон талаар

Амгалан дулааны станцын Мэдлэгийн шалгалтын комисс 56 ажилтанд мэргэжлийн зэрэг олгосон.

Мэргэжлийн зэрэг олгосон ажилтны тоог цех, хэсэг тус бүрээр харуулъя.

Хүснэгт №17

№	Цех, хэсгийн нэр	III зэрэг авсан ажилтны тоо	IV зэрэг авсан ажилтны тоо	V зэрэг авсан ажилтны тоо	VI зэрэг авсан ажилтны тоо	Зэрэг авсан нийт ажилтны тоо
1	Зуухан цех	8	10	5	-	23
2	Түлш дамжуулах цех	7	4	-	-	11
3	Цахилгаан цех	1	-	-	2	1
		2	3	-	5	4
4	Засварын цех	3	4	1	1	9
5	Хими хэсэг	5	1	-	-	6
<b>Зэрэг олгосон ажилтны тоо</b>		<b>26</b>	<b>23</b>	<b>6</b>	<b>1</b>	<b>56</b>

**Амгалан дулааны станц төхк-ийн 2025 оны сургалтын төлөвлөгөөний биелэлт**

Хүснэгт №18

№	№	Сургалтын сэдэв	Тайлбар	Сургалтанд хамруулсан		Сургалтад хамрагдах ажилтны нэрс
				Нэгжийн нэр	Хүний тоо	
<b>НЭГ. ЭРХ ОЛГОХ</b>						
1	1	Даралтат сав, шугам хоолоотой ажиллах ажилтны эрх олгох сургалт /115 хэмээс дээш дулаантай, 0.07 МПа даралттай сав, шугам хоолойтой харьцдаг/	"Хэрлэн эрдэс хими" ХХК-ийн дэргэдэх "Монголын ур чадварын сургалтын төв"-өөс 2025.09.03,04-ний өдрүүдэд зохион байгуулсан "Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах, уурын ба ус халаах зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах" сургалтад нийт 86 ажилтанг хамруулж, сертификатыг олгуулсан.	Зуухан цех	35	Зуухан цехийн ашиглалтын ажилтнууд (Үйлчлэгчээс бусад)
				Засварын хэсэг	20	Засварын цехийн дарга, ажилтнууд
				Хими хэсэг	8	Түлшний лаборант Н.Ариунжаргал, Ш.Өнөржаргал, Б.Ядамсүрэн, Ө.Саруул, Химийн аппаратчин Г.Өлзий, Б.Баярчимэг, Б.Сайнбаяр, Д.Анхзаяа
				Авто хэсэг	8	Нарийн үнсний автомашины жолооч Ш.Сандагсүрэн, Б.Өлзийбат, Т.Алтанбаатар, Х.Мөнхбат, А.Энхтайван, М.Мягмар, Н.Очирхуяг, Ж.Алтантулга
				ҮБШАХ	4	Ээлжийн инженер Б.Ган-Эрдэнэ, Б.Батзаяа, Т.Толуй, Ж.Ганбат
				Хяналтын хэлтэс	2	Техник хяналтын инженер, Т.Цэнгэл, О.Төрбат
				ДХХА хэсэг	9	ДХХА-ийн инженер К.Хызыр, А.Амаржаргал, З.Алтангас, Б.Бат-Амгалан, Б.Бат-Оргил, Э.Энхцэцэг, Д.Ганхуяг, Б.Шинэбаяр, Б.Сумъяабазар
<b>Нийт</b>				<b>86</b>		

2	1	Краны оператор, краны бүрэн бүтэн байдал хариуцагч, ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагчийн сургалт	"ЭБУ ПАРТНЕРС" ХХК-иас зохион байгуулсан 2025.09.04-ний өдөр "Краны оператор, краны бүрэн бүтэн байдал хариуцагч, ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагч"-ийн сургалтанд 52 ажилтныг хамруулж, сертификатыг олгуулсан.	Краны оператор	6	Засварчин Ч.Нямдорж, Д.Мэгзэр, П.Наранцацрал, Б.Батбилэг, М.Содномдаржаа, Н.Хонгорзул
				Шанагат хүрдэн краны оператор	6	Нуруулдан овоологчийн машинч Б.Пүрэвдалай, Г.Даваахүү, Б.Батбаясгалан, Э.Пүрэвдоржсүрэн, Түлш дамжуулахын машинч Н.Нямдэлгэр, О.Алтангэрэл
				Манипулятор краны оператор	1	Б.Жамсрандорж
				Краны аюулгүй ажиллагаа хариуцагч	11	М.Содномдаржаа, Б.Мөнгөншагай, Э.Болд, П.Мөнхбат, Ц.Баярмагнай, Б.Пүрэвдалай, Н.Сайнбилэг, Б.Борбил, Д.Өлзийдагва, Б.Нямдаваа, Н.Батцэнгэл
				Краны бүрэн бүтэн байдал хариуцагч	2	Г.Тамир, Л.Эрдэнэхүү
3	2	Оосорлогч, дохиочны эрх олгох, сунгах сургалт	"ЦДҮС" ТӨХК-иас зохион байгуулсан 2025.09.15-2025-09-18-ны өдрүүдэд "ЦАА-ны группын эрх олгох, сунгах"-сургалтанд 23 ажилтныг хамруулж байна.	Зуухан цех	8	Ээлжийн дарга Э.Очирсүх, Б.Одбаяр, Б.Отгоншар, М.Энхтөр, Түвшинболд, В.Түвшинбаяр, Д.Өлзийхишиг, Т.Баяртогтох
				Засварын цех	4	Засварчин Б.Болдбаатар, Д.Алтангэрэл, Х.Хөөхуяг, Д.Ганбаатар
				Цахилгааны хэсэг	5	Цахилгааны инженер М.Содномдаржаа, Цахилгаанчин П.Бямбадорж, Г.Бадрахбаатар, П.Энх-Од, Б.Амаржаргал
				Түлш дамжуулах цех	9	Вагон хөмрөгчийн машинч Н.Түмэн-Өлзий, О.Нууцболд, Э.Санжаадорж, Б.Эрдэнэбаатар, Ч.Чулуунбаатар, Г.Шинэбаяр, Э.Баярмагнай, Ц.Баярмагнай, Б.Пүрэвбаяр
<b>Нийт</b>				<b>52</b>		
4	1	Цахилгааны аюулгүй ажиллагааны группын эрх олгох сургалт	"ЦДҮС" ТӨХК-иас зохион байгуулсан 2025.09.15-2025-09-18-ны өдрүүдэд "ЦАА-ны группын эрх олгох, сунгах"-сургалтанд 23 ажилтныг хамруулж байна.	Удирдлага	1	Э.Мөнхжаргал
				Хяналтын хэлтэс	4	Л.Цэцэгсүрэн, О.Төрбат, Т.Цэнгэл, Д.Баасансүрэн
				ҮБШАХ	5	Т.Ангараг, Т.Толуй, Ж.Ганбат, Б.Батзаяа, Б.Ган-Эрдэнэ
				Цахилгаан цех	13	А.Нямцэрэн, М.Содномдаржаа, Г.Бадрахбаатар, П.Бямбадорж, П.Энх-Од, Г.Марал-Эрдэнэ, Б.Амаржаргал, П.Наранцацрал, Б.Зоригтбилгүүн, Б.Нямдорж, О.Гал-Эрдэнэ, Э.Одбаяр, Л.Батболд
<b>Нийт</b>				<b>23</b>		

5	1	Өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны сургалт	"Хэрлэн эрдэс хими" ХХК-ийн дэргэдэх "Монголын ур чадварын сургалтын төв"-өөс 2025.09.02-ны өдөр зохион байгуулсан "Эрсдэлтэй ажлын байр-Өндөрт ажиллах аюулгүй ажиллагаа"-ны сургалтад нийт 36 ажилтанг хамруулж, сертификатыг олгуулсан.	ДХХА хэсэг	2	ДХХА-ийн засварчин З.Алтангадас, Б.Бат-Амгалан
				Түлш дамжуулах цех	6	Нуруулдан овоологчийн машинч Б.Пүрэвдалай, Г.Даваахүү, Б.Батбаясгалан, Э.Пүрэвдоржсүрэн, Н.Нямдэлгэр, О.Алтангэрэл
				Цахилгаан цех	4	Цахилгаанчин Б.Зоригтбилгүүн, Г.Бадрахбаатар, П.Наранцацрал, Цахилгааны РХАТехникч Л.Батболд
				Зуухан цех	9	Б.Одбаяр, Г.Отгоншагай, Л.Базаргарьд, В.Түвшинбаяр, Б.Баттөр, М.Ганбямба, Б.Отгоншар, Б.Цэрэнжамц, Б.Түвшинболд
				Засварын цех	15	Засварын инженер Б.Боргил, Б.Нямдаваа, Барилга сантехник дулаан хангамжийн инженер Н.Батцэнгэл, Засварчин Ч.Нямдорж, Д.Алтангэрэл, Н.Хонгорзул, Э.Эрхэмбаяр, Х.Чойсүрэн, П.Дашдорж, Т.Ганзориг, А.Хүрэлсүх, Гагнуурчин Э.Эрхэмбаяр, Д.Ганбаатар, Д.Очирбат, Б.Энх-Эрдэнэ
<b>Нийт</b>				<b>36</b>		
<b>ДҮН</b>				<b>197</b>		
<b>ХОЁР. МЭРГЭЖИЛ ОЛГОХ</b>						
6	1	Худалдан авах ажиллагааны сургалт	2025.01.17-ны өдөр 7 ажилтнуудыг ХАА-ны АЗ-ын сургалтад хамруулсан.	СЭЗХ	2	Бараа, материалын нярав Г.Баярчимэг, С.Батбар
				ҮБШАХ	1	ҮБШАХ-ийн дарга Т.Ангараг
				Түлш дамжуулах цех	1	ТДЦ-ийн Ашиглалтын инженер Г.Тамир
				Зуухан цех	1	ЗЦ-ийн Ашиглалтын инженер Л.Эрдэнэхүү
				Хими хэсэг	1	Химийн инженер Э.Энхзул,
				Засварын цех	1	Барилга, сантехник дулаан хангамжийн инженер Н.Батцэнгэл
7	2	Эргэх механизм насосны засварчин /Ахисан/	ЭХҮТ ТӨХХК-ийн сургалтанд хамруулсан.	Засварын цех	2	ЭХҮТ ТӨХХК-ийн Эргэх механизм-Насос засварчины ахисан шатны сургалтад 2025.02.10-2025.02.28-ны хооронд Засварын инженер Д.Өлзийдагва, Засварчин Н.Хонгорзул нарыг хамруулж, сертификатыг олгуулсан.

8	3	Цахилгаан гагнуур /анхан Е-1/		Засварын цех	1	ЭХҮТ ТӨХХК-ийн Цахилгаан гагнуур /анхан Е-1/ шатны сургалтад 2025.01.06-2025.02.07-ны хооронд Засварын цехийн станцын тоног төхөөрөмжийн засварчин Б.Цог-Эрдэнэ нарыг хамруулж, сертификат олгуулсан.
9	4	Зуухны машинч /анхан шат/		Зуухан цех	9	ЭХҮТ ТӨХХК-иас зохион байгуулсан Зуухны машинчийн сургалтад 2025.08.18-2025.09.05-ны хооронд Ж.Гантулга, Б.Лувсандондов, Б.Батбилэг, Т.Баяртогтох, Н.Алдарсайхан, Г.Энхбаяр, О.Чинзориг, Ч.Оюунханд, П.Батхүрэл нарыг хамруулж, сертификат олгуулсан.
10	5	Түлшний машинч		Түлш дамжуулах цех	7	ЭХҮТ ТӨХХК-иас зохион байгуулсан Түлшний машинчийн сургалтад 2025.08.18-2025.09.05-ны хооронд Н.Батсайхан, Э.Сугармаа, П.Түвшинсанаа, Э.Мөнх-Оргил, Б.Пүрэвбаяр, П.Гансүх, Ц.Баяраа нарыг хамруулж, сертификат олгуулсан.
11	6	Дулааны процессын хэмжил, хяналт, автоматжуулалтын засварчны мэргэжил олгох		ДХХА хэсэг	3	ЭХҮТ ТӨХХК-ийн Дулааны хянах хэмжүүр, автоматикийн анхан шатны засварчины сургалтад 2025.01.27-2025.02.14-ний хооронд ДХХА-ийн засварчин Б.Бат-Оргил, А.Төмөрчөдөр, Ганхуяг нарыг хамруулж, сертификат олгуулсан.
12	7	Химийн хортой болон аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалт	"МКЛ" компанийн дэргэдэх сургалтын төвийн сургалтанд хамруулсан.	Хими хэсэг	8	"МКЛ" компанийн дэргэдэх сургалтын төвөөс зохион байгуулсан "Химийн хортой болон аюултай бодистой харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагааны ХАБЭА"-н сургалтанд 2025.05.17-ны өдөр Химийн техникч С.Баттунгалаг, Түлшний лаборант Н.Ариунжаргал, Ш.Өнөржаргал, Б.Ядамсүрэн, Ө.Саруул, Химийн лаборант Б.Нинжбадгар, С.Цэрэнпунцаг, Б.Эрдэнэбат нарыг хамруулсан.
13	8	Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторын чадавхид тавих ерөнхий шаардлага /ISO17025/	Үндэсний итгэмлэлжийн төвд хамруулсан.	Хими хэсэг	2	Үндэсний итгэмлэлжийн төвөөс "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн удирдлага, зохион байгуулалт, техникийн чадавхийг MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагад нийцүүлэх зорилгоор шаардлагын ойлголт мэдлэг олгох, арга зүйн зөвлөмж заавруудыг өгөх" талаарх сургалтад Хими хэсгийн Түлшний лаборант Б.Ядамсүрэн, Химийн техникч Б.Баттунгалаг нарыг 2025.01.30-2025.02-01-ний өдрүүдэд хамруулсан.
14	9	Цахилгаан хөдөлгүүрийн засвар /ахисан/	"Линкс майнд солюшн" ХХК-иас зохион байгуулсан сургалтанд хамруулсан.	Цахилгааны хэсэг	7	"Линкс майнд солюшн" ХХК-иас зохион байгуулсан 04 цаг 30 минутын "Цахилгаан хөдөлгүүрт засвар хийх" сургалтанд Цахилгааны инженер М.Содномдаржаа, Цахилгаанчин П.Энх-Од, П.Наранцацрал, Г.Бадрахбаатар, П.Бямбадорж, Б.Зоригтбилгүүн, Г.Марал-Эрдэнэ нарыг 2025.01.06-ны өдөр хамруулсан.

15	10	Эрчим хүчний салбарын цахилгааны инженерүүдийн сургалт		Цахилгааны хэсэг	1	ЭХҮТ ТӨХХК-иас зохион байгуулсан Эрчим хүчний салбарын цахилгааны инженерүүдийн сургалтад 2025.03.26-2025.03.28-ны хооронд Цахилгааны инженер М.Содномдаржааг хамруулсан.
16	11	Ковш мэргэжлийн сургалт		Авто хэсэг	3	"Номуун баялаг авто сургууль" сургалтын төвд 2025.09.01-2025.09.15-ны хооронд "Авто ачигчийн оператор"-ын сургалтад Ачааны автомашины жолооч Т.Сүхээ, Нарийн үнсний автомашины жолооч Б.Өлзийбат, Шуурхай ажиллагааны автомашинжы жолооч Б.Өлзийжаргал нарыг хамруулж, сертификат олгуулсан.
17	12	Үл эвдэх сорил хэт авианы		Хяналтын хэлтэс	2	ШУТИС-ХШУС-ҮЭС-ийн төвөөс зохион байгуулсан "Үл эвдэх сорилын ажилтны мэргэшил ба баталгаажуулалт стандартын дагуу ХАС"-ын I түвшний 62.5 цагийн сургалтад "ТХИнженер О.Төрбат, Т.Цэнгэл нарыг хамруулж, сертификат олгуулсан.
18	13	Химийн аппаратчин, лаборантын сургалт		Хими хэсэг	1	ЭХҮТ ТӨХХК-ийн Химийн аппаратчин, лаборантын сургалтад 2025.04.21-2025.05.09-ний хооронд Химийн аппаратчин Б.Сайнбаярыг хамруулж, сертификат олгуулсан.
19	14	“Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил, түүнд ногдуулах хариуцлага , Жолоочийн найдвартай ажиллагаа” сэдвээр мэргэшүүлэх сургалт		АХММХ	17	ХСИС-ын Замын хөдөлгөөний дүрмийн багш Дэд хурандаа Р.Мөнхбаяраар 2025.09.15-ны өдөр 8 цагийн “Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил, түүнд ногдуулах хариуцлага , жолоочийн найдвартай ажиллагаа” сэдвээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан.Сургалтанд АХМММИнженер Н.Сайнбилэг, Суудлын автомашины жолооч С.Батхишиг, Б.Өлзийжаргал, Ц.Одонхүү, Кранчин-жолооч Б.Жамсрандорж, Ачааны автомашины жолооч Т.Сүхээ, Автомеханикийн засварчин О.Цэдэн-Иш, Нарийн үнсний автомашины жолооч А.Энхтайван, Б.Өлзийбат, Ж.Алтантулга, Т.Алтанбаатар, М.Мягмар, Ц.Мөнхбат, Авто ачигчийн жолооч Б.Зулбаяр, Л.Төгсбат, Б.Батбаяр, Б.Бат-Очир нарыг тус тус хамруулсан.

20	15	Анхан шатны нэгжид удирдах ажил хийж буй хүмүүст зориулсан Мастерын сургалт	Зуухан цех	2	Зуухан цехийн элжийн дарга Э.Очирсүх, Д.Мөнх-Эрдэнэ
			ТДЦ	2	ТДЦ-ийн Ээлжийн дарга Б.Мөнгөншагай, Э.Болд
21	16	Төмөр замын Вагоны албанаас сургагч багш н.Гансүх багшаар "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагааны сургалт"	ТДЦ	47	Түлш дамжуулах цехийн 2025 оны 11-р сарын 17-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хүртэлх хугацаанд Төмөр замын вагон ашиглалтын депогоос Вагоны бүрэн бүтэн байдал хариуцагч Г.Гансүх нь "Төмөр замд ачилт буулгалт ба сэлгээний ажиллагаа хийх үед вагоны бүрэн бүтэн байдлыг хангах ерөнхий шаардлага, Ачааны вагоны бүрэн бүтэн байдал алдагдсан тохиолдолд шалтгаан нөхцөлийг судлан бүртгэх, учирсан хохирлыг тооцох төлбөр барагдуулах" сэдвээр ТДЦ-ийн нийт 47 удирдлага, ИТА, ажилтнуудад сургалт орсон.
22	17	Архив, албан хэрэг хөтлөлийн сургалт	ЗУХ	2	ЗУХ-ийн Бичиг хэргийн ажилтан Б.Буянт, Захирлын туслах Ц.Хулан нарыг Архивчдын хөгжил сургалт, арга зүйн төвийн "Архив, албан хэрэг хөтлөлийн сургалт"-нд хамруулж, үнэмлэх олгуулсан.
<b>ДҮН</b>				<b>123</b>	
<b>ГУРАВ. ХУРАЛ ЗӨВЛӨГӨӨН</b>					
23	1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх зөв ойлголт хандлагыг ажилтнуудад төлөвшүүлэх сургалт	Удирдлага, цех, хэсгүүд	66	Хуульч, өмгөөлөгч Н.Одонтуяагаас 02 цаг 30 минутын доорх сэдвүүдээр 2025.06.24-ний өдөр 40 ажилтнуудыг хамруулсан сургалтыг зохион байгуулсан. Үүнд: 1.Хүний эрхийн суурь зарчимд нийцэхгүй хөдөлмөрийн орчны зөрчлүүд 2.Ажлын байрны ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт 3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ба ажил эрхлэлт

24	2	Жендерийн эрх тэгш байдлын тухай сургалт			4.Хөдөлмөр эрхлэлт ба хөдөлмөрийн харилцаанд жендерийн эрх тэгш байдлыг хангах нь Мөн ЭХЯ-ны ажлын хэсгийн дарга Б.Хичээнгүйн баталсан хуваарь, сургалтын удирдамжийн дагуу "Жендерийн анхан шатны сургалт"-ыг компанийн удирдах ажилтан, ИТА-уудад 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 10-12 цагийн хооронд нийт 26 ажилтнуудыг хамруулж, зохион байгуулсан.
25	3	Авилгын эсрэг сургалт зөвлөгөөн зохион байгуулах	Удирдлага, цех, хэсгүүд	23	АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар У.Номин-Эрдэнэ, Г.Ариунзаяа нар компанийн хурлын тэнхимд "Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" сэдвээр 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр нийт 23 удирдлага, ИТА, мэргэжилтэн, ажилтнуудад сургалт орсон.
26	4	Худалдан авах ажиллагааны сургалт	ХААХ	2	ЭХҮТ ТӨХХК-иас зохион байгуулсан 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр "Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл хариуцсан албан хаагч"-д зориулсан сургалтанд ХААХ-ийн ХААМ мэргэжилтэн Б.Дуламсүрэн, Г.Уянга нарыг хамруулав.
27	5	Эрчим хүчний салбарын санхүү эдийн засгийн хэлтсийн ажилтнуудад олгох сургалт	Цахилгааны хэсэг	2	ЭХҮТ ТӨХХК-иас зохион байгуулсан Эрчим хүчний салбарын санхүү эдийн засгийн хэлтсийн ажилтнуудад зориулсан 2025.11.27, 28-ны өдрүүдийн сургалтад СЭЗХ-ийн Эдийн засагч Д.Долгормаа, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан боддогч Б.Оюунчимэг нарыг хамруулсан.
28	6	Эрчим хүчний салбарын химийн инженер, техникийн ажилтнуудын зөвлөгөөн	Цахилгааны хэсэг	1	ЭХҮТ ТӨХХК-иас зохион байгуулсан Эрчим хүчний салбарын химийн инженер, техникийн ажилтнуудын зөвлөгөөний 2025.05.28-2025.05.30-ны өдрүүдийн сургалтад Химийн инженер Э.Энхзулыг хамруулсан.
<b>ДҮН</b>				<b>94</b>	
<b>БҮГД</b>				<b>414</b>	

### 2.3. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ТАЛААР

#### Тайлант хугацаанд батлагдан гарсан тушаал

Гүйцэтгэх удирдлагаас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр баталсан **А** тушаал **156**, хүний нөөцийн чиглэлээр баталсан **Б** тушаал **329**, нийт **485** тушаалын үндэслэлийг холбогдох хууль эрх зүйн хүрээнд хянаж, төлөвлөсөн байна.

**Тушаалыг шинж чанараар нь төрөлжүүлэн үзүүлбэл:**


Хүснэгт №19

№	Тушаалын төрөл	Тоон үзүүлэлт	Эзлэх хувь
<b>Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр баталсан тушаал буюу А тушаал</b>			
1.	Захиргааны шинж чанартай	95	20%
2.	Худалдан авах ажиллагааны чиглэлээр	56	11%
3.	ХАБЭА, үйлдвэрлэлийн чиглэлээр	5	1%
<b>Хүний нөөцийн чиглэлээр баталсан тушаал буюу Б тушаал</b>			
4.	Хүний нөөцийн чиглэлээр	329	68%
<b>НИЙТ</b>		<b>485</b>	<b>100%</b>

#### Аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан гэрээ

Тайлант хугацаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Иргэний хууль бусад хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан нийт **109** гэрээний хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж албажуулсан байна.

График №5



**Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн талаар**

Компанийн хэмжээнд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг /цаашид ХАСХОМ гэх/ гаргах 17 албан тушаалтны мэдүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор буюу хуулийн хугацаанд эрх бүхий байгууллагын цахим системд бүрэн мэдүүлж дуусган, Гүйцэтгэх захирлын 2025 оны **01/97** тоот албан бичгээр тайлан мэдээг ЭХЯ-нд буюу толгой эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-д хүргүүлсэн.

Мөн ХАСХОМ гаргах 1 эрх бүхий албан тушаалтны эд хөрөнгөд орсон их хэмжээний өөрчлөлтийг хуулийн хугацаанд АТГ-ын цахим системд бүртгэлжүүлж албажуулсан.

Тайлант хугацаанд ажилтнуудад хуулийн мэдлэг олгох зорилгоор дараах сургалтуудыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажилласан. Үүнд:

1. АТГ-аас 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр цахимаар зохион байгуулсан “Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн талаар мэдлэг олгох, хэрхэн ХАСХОМ-ийг мэдүүлэх талаарх сургалтад мэдүүлэг гаргах 14 эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулсан.


2. АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар У.Номин-Эрдэнэ, Г.Ариунзаяа нарыг 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр урьж авчиран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт зохион байгуулж, сургалтад удирдлага, нэгжийн удирдлагууд, ИТА, мэргэжилтэн, нийт 23 хүнийг хамруулсан.

Зураг №5






Мөн Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан авлигаас урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж, уриалга, видео контент, зааврыг компанийн цахим хуудас болон дотоод сүлжээнд байршуулж, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан авлигын талаар мэдээлэх 110 дугаар бүхий зурагт хуудсыг мэдээллийн самбарт байршуулсан.



Авлигатай тэмцэх газраас уриалсан “Авлигын эсрэг нэгдье” уриалгад нэгдсэн видео шторкыг компанийн дотоод сүлжээ болон цахим сүлжээнд байршуулсан.

Зураг №8



Мөн Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан авлигаас урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж, уриалга, видео контент, зааврыг тухай бүр компанийн цахим хуудас болон дотоод сүлжээнд байршуулж, зурагт хуудас, наамал сурталчилгаа, гарын авлагыг цех, хэлтэс нэгжийн мэдээллийн самбарт байршуулсан.

Зураг №9



Шинээр ажилд орж байгаа эрх бүхий албан тушаалтнуудад авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын талаарх хууль, гарын авлагыг танилцуулах зорилгоор Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, АТГ-аас бэлтгэн гаргасан зөвлөмж зэрэг танилцах материалыг тухай бүр танилцуулсан.

### Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Тайлант хугацаанд аж ахуйн, нэгж байгууллагуудтай нийт **109** гэрээ байгуулахад оролцсон албан тушаалтнуудын ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэх **478** /давхардсан тоогоор/ хуудсыг Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах албан тушаалтанд хүлээлгэн өгч, АТГ-ын цахим хуудсанд хуулийн хугацаанд бүртгэлжүүлсэн.

Зураг №10

№	Тайлбар	Харилттай файл	Үүсгэн очноо	Төлөө	
1	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ Галас хангалал хэрэгсэл Тендер	2025-03-12		
2	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ Мод төрхт гэрээ	2025-03-12		
3	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ Үнэмт системийн зайн хавт Ду.90.80.200 Тендер	2025-03-17		
4	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ РХА салбар хэрэгсэл Тендер	2025-03-17		
5	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ Лист кубалч наалт Тендер	2025-03-17		
6	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ Копийтер принтер түүний далаан хэрэгсэл Тендер	2025-03-17		
7	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ Харуу хангалал Тендер	2025-03-18		
8	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ Цэвэрлэгчийн материал Тендер	2025-03-20		
9	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ Төрөл бүрийн резинь ролик Тендер	2025-03-20		
10	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ ТУСГ-н салбар хэрэгсэл Тендер	2025-03-20		
11	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ Цэвэрлэгчийн материал Тендер	2025-03-21		
12	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ Копийтер далаан хэрэгсэл худалдан, худалдан авалт гэрээ	2025-03-21		
13	Нийтийн албаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ав	↓ @ Галас хангалал хэрэгсэл худалдан, худалдан авалт гэрээ	2025-03-21		

### Амгалан дулааны станц ТӨХК-ийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2024-2025 онд хэрэгжүүлэхээр байгуулсан хамтын гэрээний талаар

Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Эрчим хүчний яамны төлөөлөл, МЭХГУУҮЭ-ийн төлөөлөл, Дулаан цахилгаан үйлдвэрлэгч түгээгчдийн үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл, Монголын ажил олгогч эздийн холбооны болон Монголын Эрчим Хүчний Ассоциацийн төлөөллүүд оролцож байгуулсан Эрчим хүчний салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрийг тус тус үндэслэн хамтын гэрээг ажил олгогчийн төлөөлөл, ҮЭХ-ны төлөөллүүд гэрээ байгуулан Баянзүрх дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр бүртгүүлэн мөрдөн ажиллаж байна.

Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 1.2-т заасныг хэрэгжүүлэн Амгалан дулааны станц ТӨХК-ийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2024-2025 онд хэрэгжүүлэхээр байгуулсан хамтын гэрээний 2025 оны эхний хагас жилийн биелэлтийн мэдээг Гүйцэтгэх захирлын 2025 оны 01/429, жилийн эцсийн биелэлтийн мэдээг Гүйцэтгэх захирлын 2026 оны 01/18 тоот албан бичгээр батлагдсан маягтын дагуу Эрчим хүчний яам болон МЭХГУУҮЭ-д тус тус хүргүүлсэн.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн үйл ажиллагааны тайлан-2025 он

## 2.4. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТАЛААР

### Гүйцэтгэх захирлын тушаал

Тайлант хугацаанд Гүйцэтгэх захирлын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр буюу А тушаал 156, боловсон хүчний чиглэлээр буюу Б тушаал 329 гарсан байна. Тушаалын төслийг журмын дагуу холбогдох албан тушаалтнуудаар хянуулж, албажуулсан. Тушаалын бүртгэл, хэрэгжилтийг хөтөлж байна.

График №6




### Явуулсан албан бичиг

Тайлант хугацаанд нийт 719 албан бичиг Монгол улсын Баримт бичгийн стандартын дагуу зохион бүрдүүлж, холбогдох байгууллагуудад цахимаар болон шуудангаар хугацаанд нь хүргүүлж ажилласан байна.

### Ирсэн албан бичиг

Тайлант хугацаанд 478 албан бичиг ирсэн байна. Ирсэн бичгийг удирдлагад танилцуулж, ABLE программ болон ирсэн бичгийн бүртгэл хөтөлж, удирдлагын цохолтын дагуу холбогдох албан тушаалтанд тухай бүр шилжүүлж, хяналт тавьж ажилласан.

График №7



Гүйцэтгэх захирлын тушаал болон ирсэн бичиг, явуулсан албан бичгийн тухай бүр сканнердан хавтас үүсгэн хадгалж байна.

### Ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ

Хүснэгт №20

№	Хариутай албан бичгийн тоо	Хариутай албан бичиг			Хариугүй
		Хугацаанд хариу хүргүүлсэн	Хугацаа болоогүй	Хоцорсон	
1	118	118	-	-	360

Удирдах дээд шатны байгууллагад мэдээ, тайланг хугацаанд нь хүргүүлсэн. Дурдвал:

Хүснэгт №21

Удирдах дээд байгууллагад хүргүүлсэн мэдээ, тайлан			
№	Мэдээ, тайлангийн төрөл	Байгууллагын нэр	Тайлбар
1	2	3	4
1	Гүйцэтгэх захирлын онцгой нөхцөл бүхий гэрээний биелэлт, тайлан	ТӨБЗГ, ЭХЯ	2023-2024 оны гэрээний биелэлт
2	Компанийн ХАСХОМ-н мэдүүлэг гаргасан албан тушаалтны тайлан	ЭХЯ	Хагас жил болон жилийн тайлан
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах талаар болон ХБИ ажиллуулаагүйн нөхөн төлбөр төлсөн тухай судалгаа, тайлан	ЭХЯ-ны ТЗУГ	Хагас жил, жилийн тайлан
4	Жендерийн хэрэгжилтийг хангах ажлын талаар	ЭХЯ-ны ТЗУГ	
5	Шилэн дансанд оруулах мэдээлэл	Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем	Сар бүр
6	2024-2025 оны хамтын гэрээний биелэлт	ЭХЯ, ЭХГҮҮҮЭХолбоо	Жилийн тайлан
7	Ус ашиглалтын мэдээ	Усны газар	Жилийн тайлан
8	Авлигын эсрэг үйл ажиллагааны биелэлт	ЭХЯ	Жилийн тайлан
9	Эрчист монгол ХХК-д компанийн ерөнхий мэдээлэл, хүний нөөцийн талаар болон санхүүгийн тайлан, мэдээг хүргүүлсэн.	Эрчист монгол ХХК	Тухай бүр
10	2016-2025 оны төсөв, 2026 оны төслийн тооцоолол	Эрчим хүчний яам	Төлөвлөгөөт хугацаанд
11	Архивын баримтын тоон мэдээ	Архивын ерөнхий газар	Жилийн мэдээ
12	Ус ашиглалтын мэдээ	Усны газар	Жилийн мэдээ

## **Байгууллагын архивын үйл ажиллагааны талаар**

Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам, Архивын баримтын нэр төрөл хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалтын дагуу архивын баримтыг ангилан, хадгалах хугацаа, зохион байгуулалтын нэгжийн индексийн дагуу дугаарлан хадгалж байна.

Мөн Компанийн хэлтэс, цех, нэгжийн ажилтанд архивын баримт бүрдүүлэх, үдэж хавтаслах, хадгаламжийн нэгж бүрдүүлэх ажилд арга зүйн туслалцаа үзүүлэн ажилласан.

### **Архивын баримтын хадгалалт, хамгаалалт**

Байгууллагын архивт хадгалагдаж буй байнга хадгалах, түр хадгалах хадгаламжийн нэгж болон барилга байгууламжийн зураг төслийн хадгаламжийн нэгжийг хамгаалалтын цаасан хайрцагт хийж, архивын нягтаршуулсан шүүгээнд хадгалж байна.

**Архивын нөхөн бүрдүүлэлт:** 2025 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэлтэс, цехүүдээс 301 боть баримтыг актаар хүлээн авсан.

**Байгууллагын архивын данс, бүртгэл:** Байгууллагын архивт нийт 2936-н хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Үүнд:

- Байнга хадгалах данс – 743
- 70 жил хадгалах бүртгэл – 155
- Түр хадгалах бүртгэл – 1194
- Зураг төслийн хадгаламжийн нэгжийн бүртгэл – 845 байна.

**Архивын баримт ашиглалтын талаар:** Компанийн ажлын хэрэгцээнд болон дээд газрын хяналт шалгалт, хөндлөнгийн аудит, Эрчист монгол ХХК болон шүүх, экологийн цагдаагийн газарт холбогдох баримт бичгийг тухай бүр олгож ажилласан. Зарим тохиолдолд цахимаар болон хуулбарлан олгож байна.

Байнга хадгалах дансны 743 хадгаламжийн нэгжийг сканнердан, цахим хэлбэрт шилжүүлсэн байна.

Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 270 хадгаламжийн нэгж архиваас түр олгосон байна.

### **Баримт бичгийн улсын үзлэг**

Монгол Улсын Хууль зүйн сайдын 2025 онд баталсан “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын үйл ажиллагааг дүгнэх үзүүлэлт, аргачлал”-ын дагуу ажил зохион байгуулж ажилласан.

Гүйцэтгэх захирлын тушаалаар улсын үзлэгийн Байгууллагын комисс томилсон. Уг комисс нь үйл ажиллагааг дүгнэх үзүүлэлтийн дагуу бэлтгэсэн баримттай танилцаж үнэлгээ өгч, холбогдох баримтыг Эрчим хүчний яамны дэд комисст хүргүүлсэн.

### **Хурал, зөвлөгөөн зохион байгуулсан талаар**

- Амгалан дулааны станц ТӨХК-ийн Захирлын зөвлөл нийт 18 удаа хуралдаж, хурлын тэмдэглэл хөтөлж, албажуулсан.

- Үйлдвэрлэлийн өргөтгөсөн шуурхай зөвлөгөөн тус онд 12 удаа хуралдаж, тэмдэглэл хөтөлж, өргөтгөсөн шуурхайгаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг тухай бүр холбогдох албан тушаалтнаас авч Ерөнхий инженерт танилцуулсан.
- Компани дээр зохион байгуулсан бусад хурал, зөвлөгөөний бэлтгэл хангаж ажилласан.

### Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар

2025 оны байдлаар Амгалан дулааны станц ТӨХК-ийн захиргаанд иргэн, ажилтнуудаас нийт 299 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, бүртгэн, Able программд мэдээллийг оруулж, хуулийн хугацаанд хариу хүргүүлсэн байна. Үүнд:

**Өргөдлийг утгаар нь ангилбал:**

Хүснэгт №22

№	Өргөдөл гомдол	Өргөдлийн тоо
1	2	3
1	Ажилд орох тухай	56
2	Чөлөө хүссэн тухай	47
3	Ажлаас чөлөөлөгдөх	30
4	Хүүхэд асрах чөлөө хүссэн тухай	3
5	Урт хугацааны чөлөө хүссэн тухай	1
6	Шилжин ажиллах, шилжүүлэн ажиллуулах тухай	14
7	Зайнаас ажилуулах тухай	2
8	Тэтгэмж хүссэн тухай	6
9	Өндөр насны тэтгэвэрт гарах /ажлаас чөлөөлөгдөх / тухай	3
10	Цалингийн урьдчилгаа хүссэн	2
11	Хүсэлт гаргах тухай	49
12	Хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа эргэн орох тухай	1
13	Буцалтгүй мөнгөн тусламж хүссэн тухай	14
14	Арга хэмжээ авахуулах тухай	5
15	Сул зогсолтонд хамрагдах тухай	7
16	Сул зогсолтоос татан ажилуулах тухай	3
17	Рашаан сувилал хөнгөлөлт үзүүлэх тухай	6
18	Бусад	47
Нийт		<b>299</b>

## Гэрээний бүртгэлийн талаар

2025 онд аж ахуй нэгж байгууллага болон иргэнтэй бараа, үйлчилгээ нийлүүлэх, ажил гүйцэтгүүлэх, хамтран ажиллахаар нийт 84 гэрээ байгуулж, дугаар олгосон байна. Үүнд:

Хүснэгт №23

№	Гэрээний төрөл	Сар												Нийт
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
1.	Ажил гүйцэтгэх гэрээ	1	4	1	1	9	8	2	-	5	3	2	-	36
2.	Худалдах, худалдан авах гэрээ	1	-	12	11	11	3	2	-	1	1	-	2	50
3.	Хамтран ажиллах гэрээ	4	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	7
4.	Сургалт зохион байгуулах гэрээ	-	-	-	-	1	-	-	-	4	-	-	1	6
5.	Гэнэтийн ослын даатгалын гэрээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	-	1
6.	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ	-	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	2
7.	Үйлчилгээ үзүүлэх гэрээ	-	7	1	-	-	-	-	-	-	-	-	-	8
8.	Түрээсийн гэрээ	-	-	-	-	-	-	-	-	-	2	2	-	4
9.	Хандивын гэрээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	1
<b>НИЙТ</b>													<b>127</b>	

### ГУРАВ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР


#### 3.1. ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Төлөвлөгөөний дагуу 2025 оны 1 дүгээр сарын 5-ны өдрөөс 3 зуухны горимд, 1 дүгээр сарын 25-ны өдрөөс 4 зуухны горимд тус тус шилжин ажилласан. 2025 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс 3 дугаар сарын 5-ны өдрийг хүртэл 3 зуухны горимоор ажилласан бөгөөд 3 дугаар сарын 6-ны өдрөөс 4 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл 2 зуухны горимд шилжсэн. Үүнээс хойш 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 1 зуухны горимоор ажиллаж, 5 дугаар сарын 15-ны өдөр бүрэн зогсолт хийж, сүлжээнээс таслагдан 0 горимд шилжсэн.

2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр сүлжээнд 1,530 тн/цагийн зарцуулалттай залгагдсан. Үүний дараа 10 дугаар сарын 9-ний өдрөөс сүлжээний усны зарцуулалтыг 2,370 тн/цагаар өгч 2 зуухны горимд, 11 дүгээр сарын 8-ны өдрөөс 3,500 тн/цагаар өгч 3 зуухны горимд, 12 дугаар сарын 5-ны өдрөөс 4,600 тн/цагаар өгч 4 зуухны горимд тус тус шилжин ажилласан.

## 2025 онд үйлдвэрлэсэн дулааны эрчим хүчний биелэлтийг сар бүрээр харуулбал:

График №8



2025 онд дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийг 1,157,669 Гкал байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,100,306 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж, үйлдвэрлэлийн төлөвлөгөө 57,363 Гкал-аар тасарсан.

Хүснэгт №24


Үзүүлэлт	Нэгж	2024 он	2025 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-ом.он
Дулааны эрчим хүчний үйлвэрлэл	мян.Гкал	1,041.1	1,157.7	1,100.3	57.4	59.2

## 2021-2025 оны дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийг харуулбал:

Хүснэгт №25

Үзүүлэлт	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Дулааны эрчим хүчний үйлдвэрлэл төлөвлөгөө /Гкал/	785,595	809,306	1,034,034	1,079,662	1,157,669
Дулааны эрчим хүчний үйлдвэрлэл гүйцэтгэл /Гкал/	739,460	841,820	1,037,257	1,041,125	1,100,306

График №9




2021-2025 оны хугацаанд дулааны эрчим хүч үйлдвэрлэл 48.76%-иар өссөн байна.

### 3.2 ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТҮГЭЭЛТ

2025 онд 1,136,369 Гкал дулааны эрчим хүч түгээхээр төлөвлөснөөс 1,082,753 Гкал дулааны эрчим хүч түгээсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 53,616 Гкал-аар дутуу түгээж төлөвлөгөөний биелэлт 95.3% байна. Өмнөх оноос дулааны эрчим хүч түгээлтийн төлөвлөгөөг 55,780.1 Гкал-аар илүү түгээсэн байна.

График №10




Дулааны эрчим хүч түгээлтийн төлөвлөгөө тасарсан шалтгаан нь 2025 оны 9 дүгээр сард сүлжээний усны зарцуулалтыг 1,650 тн/цагаар өгч 27,519 Гкал-аар дулаан түгээхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,535 тн/цагаар өгч 24,178 Гкал дулаан түгээж, 11 дүгээр сард сүлжээний усны зарцуулалтыг 3,700 тн/цагаар өгч 171,802 Гкал-аар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,685 тн/цагаар өгч 153,194 Гкал-аар, 12-р сард сүлжээний усны зарцуулалтыг 5,000 тн/цагаар өгч 255,173 Гкал-аар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,577 тн/цагаар өгч 219,031 Гкал дулаан түгээж нийт 53,616 Гкал дулааны эрчим хүч дутуу түгээсэн байна. Энэ асуудлаар ДҮТ ТӨХХК, УБДС ТӨХК-д тухай бүр албан тоотоор хандаж байсан боловч шийдвэрлэгдээгүй байна. Харин диспетчерийн графикийн зөрчилгүй бөгөөд горимд оногдох төлөвлөгөө 100% биелсэн болно.

Үзүүлэлт	Нэгж	2024 он	2025 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-өм.он
УБДС ТӨХК	мян.Гкал	1,025.93	1,135.29	1,081.71	53.8	55.78
Өөрийн түгээлт	мян.Гкал	1,035.7	1,080.11	1,040.77	29.68	14.73
<b>Нийт</b>	<b>мян.Гкал</b>	<b>1,026.96</b>	<b>1,136.37</b>	<b>1,082.75</b>	<b>53.62</b>	<b>55.8</b>

Дулааны эрчим хүчний түгээлтийг сүүлийн 5 жилээр графикаар харуулбал:

График №11



Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК нь жил бүрийн 3 дугаар сараас эхлэн магистрал шугамын схемийн шилжүүлэлт хийж, сүлжээний усны зарцуулалтыг бууруулдаг бөгөөд мөн өвлийн горимын схемд 10 дугаар сарын сүүлээр бүрэн шилжүүлснээр сүлжээний усны зарцуулалтыг төлөвлөгөөнөөс багаар барьж ажиллаж байна.

Хүснэгт №27

2025-2026оны халаалтын улиралд 9 дүгээр сарын 16-аас АДС-ын сүлжээнд хийгдэхсхем сэлгэн залгалтын ажлууд

№	Маг	Дулааны худаг		Ачаалал Гкал/ц	Зарцуулалт тн/ц	Схем сэлгэн залгалт	Төлөвлөгөөт хугацаа		Ачаалал шилжүүлэх сүлжээ
		Эхлэл	Төгсгөл				Эхний хугацаа	Эцсийн хугацаа	
1	2д	ДХ264	ДХ276	8.8	78	2д магистралийн ДХ264 цэгээс ДХ276 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2025-9-16-аас	2025-10-01	"АДС" ТӨХК-ийн сүлжээнд
2	5ж	ДХ5179	ДХ1253	20.9	186	5ж магистраль 5-12-ын холбоос ДХ5179 цэгээс ДХ1253 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2025-9-16-аас	2025-10-01	"АДС" ТӨХК-ийн сүлжээнд
3	5ж	ДХ5179	ДХ5221	36.9	328	5ж магистралийн хойд хэсгийн ДХ5179 цэгээс ДХ5221 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2025-10-01-аас	2025-10-10	"АДС" ТӨХК-ийн сүлжээнд
4	5ж	ДХ5138	ДХ5179	21.5	191	5ж магистралийн урд хэсгийн ДХ5138 цэгээс ДХ5179 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2025-10-01-аас	2025-10-10	"АДС" ТӨХК-ийн сүлжээнд
5	2г	ДХ253	ДХ264	30.8	274	2г магистралийн ДХ253 цэгээс ДХ264 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2025-10-10-аас	2025-10-20	"АДС" ТӨХК-ийн сүлжээнд
6	126	ДХ1227	ДХ1233	46.8	417	126 магистралийн ДХ1227 цэгээс ДХ1233 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2025-10-10-аас	2025-10-20	"АДС" ТӨХК-ийн сүлжээнд
7	126	ДХ1217	ДХ1227	72.02	641	126 магистралийн ДХ1217 цэгээс ДХ1227 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2025-10-20-аас	2025-11-01	"АДС" ТӨХК-ийн сүлжээнд


2025-2026 оны халаалтын улиралд 2 дугаар сарын хооронд АДС-ын сүлжээнд хийгдэх схем сэлгэн залгалтын ажлууд

№	Маг	Дулааны худаг		Ачаалал Гкал/ц	Зарцуулалт тн/ц	Схем сэлгэн залгалт	Төлөвлөгөөт хугацаа		Ачаалал шилжүүлэх сүлжээ
		Эхлэл	Төгсгөл				Эхний хугацаа	Эцсийн хугацаа	
1	126	ДХ1217	ДХ1227	72.02	641	126 магистралийн ДХ1217 цэгээс ДХ1227 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2026-02-26-аас	03-01-ны хооронд	"ДЦС-3" ТӨХК-ийн сүлжээнд
2	126	ДХ1227	ДХ1233	46.8	417	126 магистралийн ДХ1227 цэгээс ДХ1233 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2026-03-01-ээс	03-10-ны хооронд	"ДЦС-3" ТӨХК-ийн сүлжээнд
3	2г	ДХ253	ДХ264	30.8	274	2г магистралийн ДХ253 цэгээс ДХ264 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2026-03-11-ээс	03-20-ны хооронд	"ДЦС-4" ТӨХК-ийн сүлжээнд
4	5ж	ДХ5138	ДХ5179	21.5	191	5ж магистралийн урд хэсгийн ДХ5138 цэгээс ДХ5179 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2026-03-11-ээс	03-20-ны хооронд	"ДЦС-4" ТӨХК-ийн сүлжээнд
5	5ж	ДХ5179	ДХ5221	36.9	328	5ж магистралийн хойд хэсгийн ДХ5179 цэгээс ДХ5221 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2026-03-20-ээс	04-01-ны хооронд	"ДЦС-4" ТӨХК-ийн сүлжээнд
6	5ж	ДХ5179	ДХ1253	20.9	186	5ж магистраль 5-12-ын холбоос ДХ5179 цэгээс ДХ1253 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2026-04-01-ээс	04-10-ны хооронд	"ДЦС-4" ТӨХК-ийн сүлжээнд
7	2д	ДХ264	ДХ276	8.8	78	2д магистралийн ДХ264 цэгээс ДХ276 цэгийн хоорондох ачааллыг АДС-ын сүлжээнд шилжүүлэх схем сэлгэн залгалт.	2026-04-10-ээс	04-20-ны хооронд	"ДЦС-4" ТӨХК-ийн сүлжээнд

### 3.3 ДОТООД ХЭРЭГЦЭЭНД ЗАРЦУУЛСАН ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ

2025 онд станцын дотоод хэрэгцээнд 21,300 Гкал дулааны эрчим хүч зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 17,553 Гкал дулааны эрчим хүч зарцуулж, 3,747 Гкал дулааны эрчим хүч бага зарцуулсан.

График №12



2025 оны худалдан авалтын төлөвлөгөөнд дотоод хэрэгцээнээс дулаан авч ашиглаж буй вагон гэсгээгчид дулааны эрчим хүч (ДЭХ)-ийг тооцох тоолуур суурилуулах зардлыг тусган, тоолуур суурилуулснаар дотоод хэрэгцээнд хэрэглэж буй ДЭХ-ийг бодитойгоор хэмжин тооцох боломж бүрдсэн. Мөн дотоод хэрэгцээний халаалтын температурыг гадна агаарын температуртай уялдуулан тохируулж ажилласны үр дүнд дотоод хэрэгцээний дулааны эрчим хүчний хэрэглээг төлөвлөгөөнөөс 3,747 Гкал-аар бууруулан ажилласан байна.

График №13



2024-2025 оны халаалтын улирлаас эхлэн вагон гэгсгээгчийг шинээр ашиглалтад оруулсантай холбоотойгоор дотоод хэрэгцээний дулааны зарцуулалт өмнөх жилээс 3,401 Гкал-аар өссөн байна.

### 3.4 ЖИШМЭЛ ТҮЛШНИЙ ХУВИЙН ЗАРЦУУЛАЛТ

2025 онд жишмэл түлшний хувийн зарцуулалт 167.1 кг/Гкал байхаар төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 165.79 кг/Гкал байна. Жишмэл түлшний хувийн зарцуулалт 2025 онд 1.31 кг/Гкал-аар бага гарсан.

Үзүүлэлт	Нэгж	2024 он	2025 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-өм.он
Жишмэл түлшний хувийн зарцуулалт	кг/Гкал	171.3	167.1	165.79	1.31	5.51

Хүснэгт №28


Жишмэл түлшний хувийн зарцуулалт		1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Жиг-нэсэн дундаж
кг/Г	төлөвлөгөө	166.0	170.0	151.8	148.3	120.7	167.9	169.1	168.3	166.14	167.1
	биелэлт	166.0	170.0	151.8	148.3	120.7	172.0	184.2	165.2	170.3	165.79

Мөн 2025 оны 9 дүгээр сард зуухны ачааллыг 55-59 Гкал/цагаар, 10 дугаар сард 2 зуухыг 54-62 Гкал/цагаар ажиллуулах горим өгснөөс шалтгаалан 2 зуухны ашиггүй горимоор ажиллаж, жишмэл түлшний зарцуулалт өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт №29

Үзүүлэлт /кг/Гкал/	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Жишмэл түлшний хувийн зарцуулалт төлөвлөгөө	159.8	161.4	162.9	172.5	167.1
Жишмэл түлшний хувийн зарцуулалт биелэлт	160.7	167.8	164.9	171.3	165.79

График №14



## 3.5 НҮҮРСНИЙ ЗАРЦУУЛАЛТ

Хүснэгт №30

Нүүрсний уурхайн нэр	Зарцуулсан хэмжээ /тонн/		Дундаж дулаан гаргах чадвар /ккал/кг/		Нийт нүүрсний эзлэх хувь /%/	
	2024	2025	2024	2025	2024	2025
Цэцэнс Майнинг энд Энержи ХХК	71'924.26	16,977.22	2'909.39	3,116	17.6	4.49
Багануур ХК	29'328	144,860.5	3'600	3,691.2	7.2	38.4
Шивээ-Овоо ХК	289'276.3	208,701.5	2'968.47	3,090.5	71.03	55.3
Бат-Өөдөө ХХК /Алагтолгойн уурхай/	16'722.16	6,861.38	3'477.59	3,497.9	4.1	1.8
<b>Нийт</b>	<b>407'250.7</b>	<b>377,400.6</b>	<b>3'024.35</b>	<b>3,329.00</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>


2025 онд 407,207 тонн нүүрс зарцуулахаар төлөвлөснөөс 377,400 тонн нүүрс зарцуулж, төлөвлөсөн хэмжээнээс 29,807 тонн нүүрс бага зарцуулсан буюу 92.6%-ийн гүйцэтгэлтэй байна. 2024 онд зарцуулсан нүүрсний жигнэсэн дулаан гаргах чадвар 3,024 ккал/кг байсан бол 2025 онд 3,329 ккал/кг байсантай холбоотой нүүрсний зарцуулалт өмнөх оны гүйцэтгэлээс 29,851 тонн буюу 7.3%-иар бага зарцуулсан байна.

Дээрх хүснэгтээс 2025 онд Багануур ХК-ийн нүүрсний дулаан гаргах чадвар хамгийн өндөр буюу 3,691.2 ккал/кг, нийт нүүрсний 38.4%-ийг эзэлж байгаа ба энэ нь өмнөх оны жигнэсэн дулаан гаргах чадвараас 305 ккал/кг-аар илүү байхад гол нөлөө үзүүлсэн байна.

График №15



График №16



Нүүрсний зарцуулалт 2021-2025 оны хооронд 60.4%-иар өссөн үзүүлэлттэй байна.

### 3.6 ЗАРЦУУЛСАН НҮҮРС, ҮНСНИЙ ХАРЬЦАА

Хүснэгт №31

Үзүүлэлт	Хэмжих нэгж	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Жилээр
Нүүрсний зарцуулалт	Тонн	74100	63000	34601	21500	5500	8700	39000	51000	80000	<b>377400.6</b>
Үнсний хэмжээ	Тонн	7781	6300	3702	2176	589	869	3707	4335	7360	<b>36819</b>
Үнслэгийн хувь	Хувь	10.5	10	10.7	10.12	10.7	9.98	9.51	8.5	9.2	<b>9.8</b>

Тайлант онд нийт 377,400 тонн нүүрс зарцуулж, 36,819 тонн үнс ялгарсан байна. Жилийн дундаж үнслэгийн хэмжээ 9.8 хувьтай байв.


Ялгарсан үнснээс Налайх дүүргийн Хот тохижилтын газарт 14,149 тонн үнсийг төлбөртэй хаяж, Монцемент ХХК-д 1,181 тонн, Зэлмэ Херо ХХК-д 1,856 тонн, Арзат ХХК-д 7,470 тонн үнсийг тус тус борлуулсан байна. Мөн 12,970 тонн үнсийг силост нөөцөлж, 2,057 тонн шаарга гарсан байна.

Өмнөх онд Налайхын хот тохижилтын газарт 30,673 тонн үнс хаяж байсан бол 2025 онд 14,149 тонн үнс хаясан нь 46.1%-иар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь үнс хаях зардлыг бууруулж, үнс борлуулалтаас олох орлогыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн байна.

### 3.7 НЭМЭЛТ УСНЫ ЗАРЦУУЛАЛТ

2025 оны төлөвлөгөөнд нэмэлт усыг сүлжээнд 470,472 тонн нийлүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 248,123 тонн нэмэлт ус зарцуулж, нийт 222,349 тонн ус бага зарцуулсан байна.

График №17



Хүснэгт №32

Үзүүлэлт	Нэгж	2024 он	2025 он		Зөрүү
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Нэмэлт усны зарцуулалт	Тонн	208,712	470,472	248,123	222,349

Станцын нэмэлт усны зарцуулалт 11 дүгээр сар хүртэл ДЦС-3 ТӨХК, ДЦС-4 ТӨХК параллель схемээр ажилласантай холбоотойгоор буурсан үзүүлэлттэй гарсан. Харин 9, 10 дугаар саруудад нэмэлт усны зарцуулалтыг УБДС ТӨХК-иас төлөвлөснөөс их хэмжээгээр өгсөн.

График №18



2025 оны 12 дугаар сараас сүлжээний усны дутагдлыг ДЦС-4 ТӨХК-иас нөхөж авдаг байсныг схемийн өөрчлөлт хийн, УБДС ТӨХК-иас дан схемээр ажиллуулахаар шийдвэрлэснээр нэмэлт усны зарцуулалт өмнөх оноос дунджаар 24.6%-иар өссөн байна.

### 3.8 СҮЛЖЭЭНИЙ УСНЫ ЗАРЦУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ, СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДЛЫН АШИГЛАЛТ

2025 онд дунджаар сүлжээний усны зарцуулалтыг 3,293 тн/цаг байхаар төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 3,002 тн/цагаар барьж ажилласан байна.

Сүлжээний усны зарцуулалтын төлөвлөгөө биелээгүй нь “УБДС” ТӨХК-ийн зүгээс “ДҮТ” ТӨХХК болон “ЭХЗХ”-оос баталсан төлөвлөгөөг мөрдөлгүй, хаврын улирлын схем шилжүүлэлтийг төлөвлөгөөт хугацаанаас эрт, намрын улирлын схем шилжүүлэлтийг төлөвлөгөөт хугацаанаас хоцроож хийсэнтэй холбоотой байна. Мөн 2025 оны 01 болон 12 дугаар саруудад гадна агаар олон жилийн дунджаас дулаахан байсантай холбоотой сүлжээний усны зарцуулалт буурсан байна.

Хүснэгт №33

Үзүүлэлт	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Сүлжээний усны зарцуулалт Төлөвлөгөө /тонн/цаг/	2417	2751	2966	2949	3293
Сүлжээний усны зарцуулалт Гүйцэтгэл /тонн/цаг/	2302	2552	2881	2930	3002

График №19




Сүлжээний усны зарцуулалт 2021-2025 оны хооронд Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээнээс хамааран 30%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт №34

Үзүүлэлт	Нэгж	2024 он	2025 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-өм.он
Сүлжээний усны зарцуулалт	тонн/цаг	2930	3293	3002	91.2%	102.5%


График №20



2025 онд Амгалан дулааны станц ТӨХК нь Улаанбаатар хотын нийт түгээлтийн 13.1% буюу 1,082,753 Гкал дулааныг түгээсэн байна.

2025 онд суурилагдсан хүчин чадлын оргил ачаалал нь 12 дугаар сард 74.7% хүрсэн бол хамгийн бага ачаалал нь 5 дугаар сард 15.5%-ийн ачаалалаар ажилласан байна.

График №21



2024 онд төслийн хүрээнд станцыг 116 МВт хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөсөнтэй холбоотойгоор суурилагдсан хүчин чадлын ашиглалтын хувь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй гарсан байна.

### 3.9 Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-иас өгсөн горимын биелэлт

Хүснэгт №35

Үзүүлэлт	Нэгж	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Жил-эр
Температурын горим	°С	118,32/59	116.9/59	102.7/54.6	93.4/51.5	87.6/49.2	85.6/48.2	93.9/51.5	106.3/56	118.2/59.4	106.3/56
Температурын гүйцэтгэл	°С	119.6/56.9	117.5/53.4	104.0/50.2	94.5/46.05	88.39/45.92	86.36/40.84	94.4/44.2	106.9/49.7	118.8/54.9	106.9/49.7
Даралтын горим төлөвлөгөө	ата	8.8/2.0	8.5/2.0	8.4/2.0	8.0/2.0	7.0/2.0	7.0/2.0	7.3/2.0	7.9/2.0	8.9/2.0	7.9/2.0
Даралтын горим гүйцэтгэл	ата	8.8/2.0	8.5/2.0	8.4/2.0	8.0/2.0	7.0/2.0	7.02.0	7.3/2.0	7.9/2.0	8.9/2.0	7.8/2.0
Сүлжээний усны зарцуулалт төлөвлөгөө	Тонн/цаг	4750	3800	2900	2400	1550	1650	2940	3700	5000	3188
Сүлжээний усны зарцуулалт гүйцэтгэл	Тонн/цаг	4263	4070	2803	1977	1345	1535	2764	3685	4577	3002

2025 онд дунджаар температурын горимыг 106.9/49.7°С, даралтын горимыг 7.8/2.0 ата, сүлжээний усны зарцуулалтын горимыг 3,002 тн/цагаар барьж ажилласан. ДҮТ ТӨХХК-иас өгсөн горимыг цаг тутамд барьж горимын зөрчилгүй ажилласан.

### 3.10. ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ

Тайлант онд дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 2024 онтой харьцуулахад 61,198 Гкал-аар нэмэгдсэн. Үйлдвэрлэлийг 4 зуухны ашигтай горимоор ажиллуулснаар тоноглолууд бүрэн ачаалал авч цахилгааны эрчим хүчний хувийн зарцуулалт төлөвлөгөөнөөс 2.8 кВт/Гкал-аар буурсан байна.

Хүснэгт №36


Үзүүлэлт	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
ЦЭХ-ний зарцуулалт /МВт/	24963	28852	37133	35451	38588.8

График №22



2021–2025 оны хооронд цахилгааны зарцуулалт 54.6%-иар өссөн байна. 2025 онд дулаан үйлдвэрлэлийн хэмжээ 2024 оноос 61.2 мян.Гкал-аар өссөнөөс шалтгаалан цахилгааны зарцуулалт 3,137.54 МВт-аар өссөн.


График №23



### 3.11 НҮҮРС ТАТАН АВАЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

Хүснэгт №37

№	Компанийн нэр	Төлөвлөгөө /тн/	Гүйцэтгэл /тн/	Хувь/%/	Вагоны тоо	Эзлэх хувь /%/
1	Шивээ-Овоо ХК	220304	214810.93	97.5	3298	58.7
2	Цэцэнс майнинг энд энерги ХХК	12330	12330	100	190	3.3
3	Бат-Өөдөө ХХК	8721	9501.60	108.9	146	2.6
4	Багануур ХК	140000	128878.11	91.75	1982	35.3
<b>Дүн</b>		<b>381355</b>	<b>365519.21</b>	<b>95.84</b>	<b>5867</b>	<b>100</b>



Нийт нүүрс татан авалтын хэмжээг өмнөх онтой харьцуулахад 2024 онд **417,150** тонн байсан бол 2025 онд **381,355.21** тонн болж, **35,795.79** тонн буюу **8.5** хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2025 онд Шивээ-Овоо ХК, Цэцэнс Майнинг энд Энержи ХХК, Бат-Өөдөө ХХК, Багануур ХК-тай нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулж, төлөвлөсөн татан авалтыг сар бүрийн хуваарийн дагуу жилийн хугацаанд хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд нийт **5,867** вагон буюу **365,519.21** тонн нүүрс татан авч, нөөц бүрдүүлсэн бөгөөд гүйцэтгэл **95.8** хувьтай биелэсэн.

Төлбөрийн үлдэгдэлтэй холбоотойгоор 12 дугаар сард Багануур ХК-иас **8,200** тонн нүүрс татан авалт тасалдсан. Мөн цаг агаарын дулааралтай холбоотойгоор 3, 4 дүгээр сард төлөвлөсөн хэмжээнээс бага хэмжээгээр нүүрс татан авалт хийгдсэн.

Уурхай тус бүрийн нүүрсний чанарын үзүүлэлтийг дараах хүснэгтэд үзүүлэв.

### Нүүрсний чанар:

Хүснэгт №38

№	Компанийн нэр	Чийглэг W %	Үнслэг А %	Дэгдэмхий V %	Хүхэрлэг S %	Илчлэг Q Ккал/кг
1	Шивээ-Овоо ХК	39.19	8.94	43.81	0.93	3,090.5
2	Цэцэнс ХХК	37.00	9.71	47.53	0.90	3,116
3	Бат-Өөдөө ХХК	12.50	31.16	41.41	0.90	3,497.9
4	Багануур ХК	32.63	10.13	43.01	0.73	3,691.2

Нүүрсний чанарын хувьд Шивээ-Овоо ХК-ийн нийлүүлсэн нүүрсний дундаж илчлэг 3, ккал/кг, Цэцэнс Майнинг энд Энержи ХХК-ийн 3,116 ккал/кг, Бат-Өөдөө ХХК-ийн 3,497.9 ккал/кг, Багануур ХК-ийн 3,691.2 ккал/кг байгаа нь гэрээнд заасан чанарын шаардлагыг бүрэн хангаж байна.

## Нүүрс нөөцлөлт:

## Хүснэгт №39

Сар	2024 /хоног/	2025 /хоног/	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	7	13	34,479.78	72,376.32	74,100	32,756.10
2	4	9	32,756.10	50,491.91	63,000	20,248.01
3	7	9	20,248.01	25,516.90	34,600.6	11,164.31
4	5	5	11,164.31	13,741.50	21,500	3,405.81
5	5	9	3,405.81	2,118.05	5,500	23.86
9	31	42	23.86	31,939.85	8,700	23,263.71
10	29	27	23,263.71	50,536.13	39,000	34,799.84
11	19	24	34,799.84	56,737.97	51,000	40,537.81
12	16	9	40,537.81	62,427.52	80,000	22,965.33

Тухайн сарын талбайн үлдэгдлийг тухайн сарын хоногийн зарцуулалтад харьцуулвал:

График №25



Нүүрсний үндсэн агуулахад 13,000 тонн, шинээр баригдсан агуулахад 10,000 тонн нүүрсийг тус тус битүү агуулахад нөөцөлсөн. Мөн 22,000 тонн нүүрсийг нэмж нөөцлөх зорилгоор захиргааны байрны хойд талд шинээр талбай засаж 9,000 тонн, вагон гэсгээгчийн барилгын зүүн талд 3,000 тонн, спорт заалны урд 8,500 тонн, силосын хажууд 1,500 тонн нүүрс нөөцөлж, станцын нүүрсний нөөцийг 22 хоногоор бүрдүүлсэн. Харин өвлийн оргил ачааллаар тооцоход 15–17 хоногийн нөөц бүрдүүлж ажилласан. 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 39,074.5 тн нүүрс нөөцөлсөн.

Хүснэгт №40

Сар	Төлөвлөгөө /тн/	Гүйцэтгэл /тн/	Хувь	Вагоны тоо
1	43,306	42,432	97.9	653
2	38,706	32,506.8	83.6	498
3	25,000	16,629.15	66.6	256

4	15,000	8,456.05	56.3	130
5	3,000	2,118.05	70.6	33
9	20,000	20,839.65	104.1	321
10	25,000	30,532.21	122.1	470
11	25,000	25,950.85	103.8	399
12	35,000	35,346.17	99.7	538
<b>Дүн</b>	<b>220,304</b>	<b>214,810.93</b>	<b>97.5</b>	<b>3255</b>

График №26



2025 онд Амгалан дулааны станц ТӨХК, Шивээ-Овоо ХК-ийн хооронд нүүрс худалдах, худалдан авахаар байгуулсан ( ШО24-1/09, 24/63: ШО25-1/02, 25/24 ) тоот гэрээний дагуу уурхай нь станцад **220,304** тонн нүүрс нийлүүлэхээс **214,810.93** тонн нүүрс нийлүүлж **97.5%-**иар төлөвлөгөөг биелүүлсэн. Цаг агаарын дулааралтай холбоотой төлөвлөгөөт нүүрс татан авалтаас бага татан авалт хийгдсэн.

Гэрээний хугацаанд **3,255** вагон нүүрс ачиж нийлүүлсэн. Жилийн хугацаанд уурхайгаас нийлүүлсэн нүүрсний дундаж чийглэг **39.19%**, үнслэг **8.94%**, хүхэрлэг **0.93%**, дэгдэмхий **43.81 %** тооцоонд авсан дундаж илчлэг **3161.0** Ккал/кг гарсан нь чийглэг өндөр үзүүлэлттэй байсан ба бусад нь гэрээний болон стандартын шаардлагыг хангаж байна.

Жилийн хугацаанд нэг вагон нүүрсний дундаж жин **65.8** тонноор даацанд хүргэж ачсан байна.

Гэрээнд чийглэг 41.2-448% заасан байгаагаас дундаж чийглэг 39.19%-тай гарч, чийглэг багатай, дулаан гаргах чадвар өндөртэй нүүрс нийлүүлэгдсэн байна.

**Цэцэнс майнинг энд энерги ХХК:**

Хүснэгт №41

Сар	Төлөвлөгөө /тн/	Гүйцэтгэл /тн/	Хувь	Вагоны тоо
1	12,330	12,330	100	190
<b>Дүн</b>	<b>12,330</b>	<b>12,330</b>	<b>100</b>	<b>190</b>

2025 онд Амгалан дулааны станц ТӨХК, Цэцэнс майнинг энд энерги ХХК-ийн хооронд нүүрс худалдах, худалдан авахаар байгуулсан 24/112 тоот гэрээний дагуу уурхай нь станцад **12,330 тонн** нүүрс нийлүүлэхээс **12,330 тонн** нүүрс нийлүүлж **100%** биелэгдсэн. Уурхай нь станцад гэрээний хугацаанд **190** вагон нүүрс ачиж нийлүүлсэн.

Гэрээний хугацаанд уурхайгаас нийлүүлсэн нүүрсний дундаж чийглэг **37%**, үнслэг **9.71%**, дэгдэмхий бодис **47.53%**, хүхэрлэг **0.9%**, дундаж илчлэг **3,116** Ккал/кг гарсан нь илчлэг гэрээний болон стандартын шаардлагыг хангасан байна. Нэг вагон нүүрсний дундаж жин **65** тонн гарсан нь даацандаа хүргэж ачсан байна.

**Бат-Өөдөө ХХК:**

Хүснэгт №42

Сар	Төлөвлөгөө /тн/	Гүйцэтгэл /тн/	Хувь	Вагоны тоо
1	2410	2410.4	100	37
2	1311	1918.3	146.3	30
12	5000	5172.9	103.4	77
<b>Дүн</b>	<b>8721</b>	<b>9501.6</b>	<b>108.9</b>	<b>146</b>

Амгалан дулааны станц ТӨХК нь Бат-Өөдөө ХХК-тай нүүрс худалдах, худалдан авахаар байгуулсан 24/66, 25/103 тоот гэрээний дагуу уурхай нь станцад **8,721 тонн** нүүрс нийлүүлэхээс **9,501.6 тонн** нүүрс нийлүүлж **108,9%** биелэгдсэн.

Уурхай нь станцад гэрээний хугацаанд **146** вагон нүүрс ачиж нийлүүлсэн.

Гэрээний хугацаанд уурхайгаас нийлүүлсэн нүүрсний дундаж чийглэг **12.50%**, үнслэг **31.16%**, дэгдэмхий бодис **41.41%**, хүхэрлэг **0.9%**, дундаж илчлэг **3,910.0** Ккал/кг гарсан нь гэрээний болон стандартын шаардлагыг хангаж байна.

**Багануур ХК:**

Хүснэгт №43

Сар	Төлөвлөгөө /тн/	Гүйцэтгэл /тн/	Хувь	Вагоны тоо
1	10,000	15,204	152.04	234
2	20,000	16,066.81	80.3	247
3	10,000	8,887.75	88.8	137
4	10,000	5,285.45	52.8	81
9	10,000	11,100.2	100	171
10	20,000	20,003.92	94.8	308
11	30,000	30,585.2	98.3	470
12	30,000	21,744.79	69.7	331
<b>Дүн</b>	<b>140,000</b>	<b>128,878.11</b>	<b>91.75</b>	<b>1982</b>

2025 оны 01 дүгээр сард Амгалан дулааны станц ТӨХК, Багануур” ХК-ийн хооронд нүүрс худалдах, худалдан авахаар байгуулсан (25/04, 25/13-07) тоот гэрээний дагуу уурхай нь гэрээний хугацаанд Амгалан дулааны станцад **140,000** тн нүүрс нийлүүлэхээс **128,878.11** тн нүүрс нийлүүлж **91.75%** биелэгдсэн. Уурхай нь Амгалан дулааны станцад гэрээний хугацаанд 1982 вагон нүүрс ачиж нийлүүлсэн. Уурхайгаас нийлүүлсэн нүүрсний дундаж

чийглэг **32.63%**, үнслэг **10.13%**, дэгдэмхий **43.01%**, хүхэрлэг **0.73%**, дундаж илчлэг **3,688** Ккал/кг гарсан нь гэрээний болон нүүрсний стандартын шаардлагыг хангаж байна.

Гэрээт хугацаанд нэг вагон нүүрсний дундаж жин **65.62** тонноор даацанд хүргэж ачсан байна.

### 3.12 УС ХАНГАМЖ, ХЭРЭГЛЭЭ

Ус сувгийн удирдах газрын Ø65, Ø150, Ø133 шугамын тоолуур, № 2, 4, 5, 7, 8, 9, 10, 11-р худгийн ерөнхий тоолуурын заалтыг сар бүрийн эхэнд авч УСУГ-тай болон, Баянзүрх дүүргийн татварын хэлтэстэй ус ашиглалтын тооцоо хийсэн. № 1, 3, 6-р худаг усны ундаргагүй болсоноос ашиглахгүй байна. Нийт усны 16.7%-ийг УСУГ-ын ус, 69.6%-ийг худгийн ус, 3.2%-ийг хөрс, голын ус, 10.4%-ийг бохир ус эзэлж байна.


УСУГ-аас сар бүрийн 03-05-ны өдөр усны 3ш тоолуурын заалтыг 2 талаас хамтран авч тооцоо тулгасан. Жилийн хугацаанд 49,149 м<sup>3</sup> цэвэр ус, 16,925 м<sup>3</sup> бохир усны тооцоо хийсэн. Станцын технологийн хэрэглээнд 262,391 м<sup>3</sup> цэвэр ус зарцуулсан.

Улиастайн гол, гүний худаг № 4, 5, 7, 8, 9, 10, 11-ийн ерөнхий тоолуур болон худаг №2-д сар бүрийн 01-ний өдөр тоолуурын заалт авч худгийн ус 203,816 м<sup>3</sup>, улиастайн голын 9,426 м<sup>3</sup> ус авч ашигласан байна.

Хүснэгт №44

Үзүүлэлт	Цэвэр ус	Худгийн ус	Хөрс, голын ус	Бүгд	Бохир ус
м <sup>3</sup>	49,149.00	204,816.00	9,426.00	280,316.00	16,925.00
Хувь /%/	17.5	73.0	3.4	100.00	6.0

График №27



#### Цэвэр, бохир ус:

2025 оны 02-05 дугаар сард худаг, хөрсний усны ундарга багассанаас технологийн хэрэгцээнд шаардлагатай усыг УСУГ-аас их хэмжээний цэвэр ус авч хэрэглэсэн.

#### Цэвэр ус /м<sup>3</sup>/

Хүснэгт №45

сар	2021	2022	2023	2024	2025
1	4,340.00	819.00	4,469.00	3,330.00	4450
2	3,485.00	311.00	859.00	2,010.00	2690
3	5,652.00	740.00	4,070.00	10,840.00	1990
4	1,333.00	1,670.00	8,340.00	5,280.00	820

5			3,655.00	4,600.00	470
6				80.00	
7				60.00	
8				80.00	
9	2,760.00	870.00	1,580.00	100.00	103
10	240.00	610.00	420.00	60.00	2946
11	3,379.00	3,370.00	8,520.00	1,340.00	3555
12	1,521.00	12,851.00	3,250.00	1,100.00	32424
<b>Дүн</b>	<b>22,710.00</b>	<b>21,241.00</b>	<b>35,163.00</b>	<b>28,880.00</b>	<b>49,149.00</b>

Хүснэгт №46

Бохир ус /м <sup>3</sup> /					
сар	2021	2022	2023	2024	2025
1	418.00	268.00	659.00	551.00	540
2	235.00	511.00	556.00	671.00	675
3	625.00	796.00	713.00	2,303.00	556
4	445.00	454.00	994.00	987.00	418
5			355.00	863.00	397
6				380.00	
7				360.00	
8				380.00	
9	1,719.00	781.00	630.00	400.00	403
10	539.00	214.00	680.00	357.00	344
11	401.00	358.00	1,435.00	530.00	52
12	436.00	1,447.00	615.00	1.00	12,778.00
<b>Дүн</b>	<b>4,818.00</b>	<b>4,829.00</b>	<b>6,637.00</b>	<b>7,783.00</b>	<b>16,925.00</b>

Хүснэгт №47

Худаг, хөрс, голын ус:/м <sup>3</sup> /			
Сар	Худаг	Хөрс, гол	Бүгд
1	42,216.00		42,216.00
2	23,799.00		23,799.00
3	16,426.00		16,426.00
4	19,190.00		19,190.00
5	4,638.00		4,638.00
9	18,526.00		18,526.00
10	25,255.00	9,426.00	15,829.00
11	25,829.00		25,829.00
12	28,937.00		28,937.00
<b>Дүн</b>	<b>204,816.00</b>	<b>9,426.00</b>	<b>214,242.00</b>


Усны хэрэглээг өмнөх онтой харьцуулахад цэвэр ус 20,269 тонн буюу 70.0%-иар нэмэгдсэн нь 2025 оны 12 дугаар сараас эхлэн Амгалан ДС нь бусад сүлжээнээс хамааралгүй схемд шилжсэнтэй холбоотой нэмэлт усны зарцуулалт 1,500-2,000 тн/ц-ын зарцуулалттай болж нэмэгдсэн байна. Мөн нэмэлт усны зарцуулалт ихэссэнтэй холбоотой худгийн усны хэрэглээ 203,816.0 тонн болж өссөн нэмэгдэж, өмнөх оноос 79,126 тн буюу 63%-иар ихэссэн байна. Ус хангамжийг нийт дүнгээр тооцоход 2024 онд 162,995.0 тн усыг

технологийн болон ахуйн хэрэглээнд хэрэглэж байсан бол 2025 онд 262,391.0 тн ус хэрэглэж өмнөх оноос 99,396.0 тн ус буюу 60%-иар хэрэглээ нэмэгдсэн үзүүлэлтэй байна.

Хүснэгт №48

Он	Цэвэр	Худаг	Хөрс, гол	Нийт	Үүнээс бохир
2024	28,880.00	124,690.00	9,425.00	162,995.00	7,783.00
2025	49,149.00	203,816.00	9,426.00	262,391.00	16,925.00
зөрүү	(42,866.00)	79,126.00	(1)	(99,396.00)	22,986.00
хувь	170.1	163.4	100	160.9	395.3

График №28



Хүснэгт №49

Дотоод хэрэгцээнд ашигласан ус /м³/						
Сар	Х/н	Оффис	Зуух	Угаалга	Хятад ажилчдын ахуйн байр	Дүн
1	м3	21	323	23	14	381
2	м3	19	15	24	15	73
3	м3	15	13	14	13	55
4	м3	21	15	10	10	56
5	м3	18	9	9	16	52
6	м3	32	100	30	20	182
7	м3	30	150	21	23	224
8	м3	32	125	29	25	211
9	м3	41	74	83	49	247
10	м3	14	33	19	0	66
11	м3	26	18	25	0	69
12	м3	26	59	53	0	138
<b>Дүн</b>		<b>295</b>	<b>934</b>	<b>340</b>	<b>185</b>	<b>1754</b>
<b>Хувь</b>		<b>16.81</b>	<b>53.24</b>	<b>19.38</b>	<b>10.54</b>	<b>100.00</b>


График №29



Хүснэгт №50

Үнс хаях, зайлуулах							
сар	Налайх дүүргийн хот тохижилтийн газар /тн/	Монцемент ХХК /тн/	Нөөцөлсөн үнс /тн/	Шаарга /тн/	Зэлмэ херо	Арзат	Нийт /тн/
1	5987		1743	51			7781
2	5330	113	614	243			6300
3	614		2932	156			3702
4	71	672		250	918.52	3964	2176
5				10	937.4	2049	589
6						956	
9			50	21		500	869
10		396	1523	310			3707
11	670		2015	266			4335
12	1477		4093	750			7360
<b>Дүн</b>	<b>14149</b>	<b>1181</b>	<b>12970</b>	<b>2057</b>	<b>1856</b>	<b>7470</b>	<b>36819</b>


График №30



### 3.13. ТОНОГЛОЛЫН АЖИЛЛАСАН ЦАГ


Зуухны ажилласан цаг:

График №31




## Зуухны ажилласан байдал:

График №32




## Зарцуулсан нүүрс болон зуухнаас гарсан үнсний харьцуулалт (тонн)

График №33




## Компрессорын ажилласан цаг

График №34



## Сүлжээний усны насосны ажилласан цаг

График №35



## Ус зөөлрүүлэх төхөөрөмжийн ашиглалтын үеийн тооцоо

Хүснэгт №51

д/д	Он сар өдөр	УЗТ №1	УЗТ №2	УЗТ №3	УЗТ №4,5	Үүсгэвэр усны хатуулаг	Боловсруулсан ус	Зарцуулсан давсны хэмжээ
		Сэргээлтийн тоо				(мкг*экв/дм <sup>3</sup> )	(тн)	(кг)
1	1-р сар	18	15	12	-	5669	15114	30200
2	2-р сар	17	17	18	-	5398	10836	21800
3	3-р сар	29	27	25	-	5740	12656	24400
4	4-р сар	28	20	22	-	5764	10697	21500
5	5-р сар	15	6	14	-	5084	5669	8000
6	9-р сар	17	8	12	-	5433	4879	6000
7	10-р сар	45	13	48	-	5372	11936	21200
8	11-р сар	60	22	58	45	4727	8165	16800
9	12-р сар	65	36	68	46	3505	27924	23000
<b>Нийт</b>		<b>294</b>	<b>164</b>	<b>277</b>	<b>91</b>	<b>5188</b>	<b>107876</b>	<b>172900</b>

## Түлш дамжуулах тоноглолын ажилласан цагийн үзүүлэлт /цаг/

Хүснэгт №52

Тоноглол	1сар	2сар	3сар	4сар	5сар	9 сар	10сар	11сар	12сар	НИЙТ
ЛК-1	280	207	115	50	5	54	162	182	228	<b>1283</b>
ЛК-2	73	76	68	24	2	4	6	19	39	<b>311</b>
ЛК-3А	133	103	0	98	1	33	84	154	118	<b>724</b>
ЛК-3Б	199	170	185	17	42	5	61	74	190	<b>943</b>
Анхдагч Бутлагч-А	133	103	0	98	1	33	84	154	118	<b>724</b>
Анхдагч Бутлагч-Б	199	170	185	17	42	5	61	74	190	<b>943</b>
Хоёрдогч Бутлагч-А	133	103	0	98	1	33	84	154	118	<b>724</b>
Хоёрдогч Бутлагч-Б	199	170	185	17	42	5	61	74	190	<b>943</b>
ЛК-4А	133	103	0	98	1	33	84	154	118	<b>724</b>

<b>ЛК-4Б</b>	199	170	185	17	42	5	61	74	190	<b>943</b>
<b>ЛК-5А</b>	133	132	90	58	22	20	70	114	140	<b>779</b>
<b>ЛК-5Б</b>	199	141	95	58	21	20	76	114	173	<b>897</b>
<b>ЛК-6</b>	76	45	10	66	43	60	101	103	103	<b>607</b>
<b>ЛК-7</b>	73	76	68	24	2	4	6	19	39	<b>311</b>
<b>Туузан тэжээгч-1</b>	139	103	57	25	3	27	81	101	89	<b>625</b>
<b>Туузан тэжээгч-2</b>	138	104	58	25	2	27	81	101	89	<b>625</b>
<b>Вагон хөмрөгч</b>	232	165	77	34	4	60	140	202	178	<b>1092</b>
<b>Нуруулдан овоологч</b>	78	45	12	66	43	60	101	103	103	<b>611</b>
<b>Нийт</b>	<b>2749</b>	<b>2186</b>	<b>1390</b>	<b>890</b>	<b>319</b>	<b>488</b>	<b>1404</b>	<b>1970</b>	<b>2538</b>	<b>13809</b>
<b>НИЙТ</b>										

**Дотоод хэрэгцээний цэх-ний ухаалаг тоолуураар тоноглолын хэрэглээг хянаж, оргил ачааллын үеийн цэх-ний хэрэглээг бууруулах**

Амгалан дулааны станц ТӨХК нь ЦДҮС ТӨХК-ийн харъяа “Дулаан” дэд станцаас нүүрс бутлуур А,Б, үндсэн барилгын А,Б, вагон хөмрөгчийн А,Б, нуруулдан овоолох гэсэн 7 гаргалгаагаар тэжээгддэг. Өөрийн дотоод хэрэгцээнд ТДЦ-ийн ЛК №4 А,Б, ЛК №5 А,Б гаргалгаа, химийн хэсэг, оффисын байрны цахилгааны тэжээлд ЦЭХ-ний ухаалаг тоолууруудыг нэмж суурилуулснаар үндсэн болон туслах тоноглолуудын хоногт хэрэглэсэн ЦЭХ-ийг тооцоолох боломжтой болсон. Ингэснээр станцын хэмжээнд нийт цахилгаан тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж оргил ачааллын үеэр шаарганы конвейр №1,2,3,4, шаарга хөргүүр №1,2,3,4, бутлуур А,Б, вагон хөмрөгч Б, ЛК №5, нуруулдан овоологчийг ажилд залгахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 17-22 цагийн ЦЭХ-ний хэрэглээ 2025 оны 11,12 дугаар саруудад төлөвлөснөөс 505.5 МВт-аар бууруулсан.

**Их болон урсгал засвар, хөрөнгө оруулалт, тзбах-ээр гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, түүний биелэлт**

Амгалан дулааны станц нь 2025 оны 05 дугаар сарын 15-ээс эхлэн зуны “О” зогсолт хийж 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд засварын ажлыг 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах **их болон урсгал засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ-ээр гүйцэтгэх ажлын** төлөвлөгөөг гарган баталсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэл 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 99.7%-тай биелэгдсэн.

**Их засвар:** Их засвараар хийгдэх 2 ажлаас Барилгын гадна фасад засварын ажил 100%, Зуух №3-ын их засварын ажил 100% гүйцэтгэлтэй байна.

**ТЗБАХ:** ТЗБАХ-ээр хийгдэх 7 ажлаас Дулааны мөнгөн тооцооны програмын засвар үйлчилгээ, программ хөгжүүлэлт хийх, ЛК-№3-с бутлуур буух хоолой дээр шигшүүр хийх ажлууд 100% дууссан. Түлш дамжуулахын цахилгаан хөдөлгүүрүүдийн тусгаарлагч сэргээх, хэмжилт хийх ажил 100% дууссан. Химийн нэмэлт усны тоолуурын программ хангамж ажил 100% дууссан. Цахилгаан редуктор бүхий алсын удирдлагатай хаалт ажил 100% дууссан. Шат тавцан хийлгэх ажил 100% дууссан. Зуух №2-ын халах гадаргууг хэсэгчлэн солих ажил 100% дууссан. ТЗБАХ-ээр хийгдэх ажил 100% гүйцэтгэлтэй байна..

**Хөрөнгө оруулалтын ажил:** Хөрөнгө оруулалтын нийт 15 ажлаас ажил 15 ажил 100% худалдан авалт хийгдсэн. Нийт 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

**Урсгал засварын ажил:** Зуух №1,2,3,4-н үндсэн болон туслах тоноглолуудын засвар үйлчилгээ, ТДЦ-ийн тоноглол, хими, цахилгаан, РХА, ДХХА, ТУСПИ, Авто хүнд машин механизмын урсгал засварт нийт 1228 ажил хийхээр график төлөвлөгөө гарган батлуулж 4-р сараас эхлэн графикайн дагуу 1219 ажил бүрэн хийгдэж ажлын гүйцэтгэл 99.1% биелэгдсэн.

### **ДӨРӨВ. АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЦЭЭНД М-СИ-ЭС КОКА-КОЛА ХХК-ИЙН ҮЙЛДВЭРИЙН ЦЭВЭРЛЭСЭН ХАЯГДАЛ УСЫГ ДАХИН АШИГЛАХ ТӨСӨЛ**

Энэхүү төслийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хүсэлтээр Дэлхийн Банкны “2030 Усны нөөцийн бүлэг” нь 2020-2024 онд БНСУ-ын Ногоон хөгжлийн итгэлцлийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж, дулааны станцын технологийн хэрэгцээнд компанийн М-си-эс кока-кола ХХК-ийн үйлдвэрийн цэвэрлэсэн хаягдал усыг ашиглах боломжтой болохыг баталгаажуулан тогтоосон.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн суурилагдсан хучин чадлыг 2024 онд 116 МВТ-аар нэмэгдүүлснээр тус станцын усны хэрэгцээ нэмэгдэж, нэмэлт эх үүсвэр шаардлагатай болсон. Тус ажлын хүрээнд нэмэлт ус хангамжид М-Си-Эс Кока-Кола компанийн үйлдвэрийн хаягдал усыг дахин ашиглах тухай хоёр тал хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурах ажиллагаа 2024 оны 11 дүгээр сард явагдаж, бүтээн байгуулалтын ажил эхэлсэн.

М-Си-Эс Кока-Кола компанийн усны эх үүсвэрийг хамгаалах зорилгын хүрээнд хоногт 2000 тн ус цэвэршүүлэх хүчин чадалтай, дэвшилтэт технологи бүхий “Хаягдал ус цэвэршүүлэх байгууламж”-аас гарсан ус нь “Монгол Улсын хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэрлэгдсэн хаягдал усны MNS 4943:2015” стандарт болон MNS 6734 : 2018 “Дахин ашиглах цэвэрлэсэн ус, техникийн ерөнхий шаардлага” стандартанд нийцсэн цэвэршүүлсэн ус юм.

Цэвэршүүлсэн хаягдал усыг дахин боловсруулж, үйлдвэрийн хэрэгцээнд дахин ашигласнаар Монгол улсын “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсыг 2021-2025 он хүртэл хөгжүүлэх 5 жилийн ерөнхий үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, нийслэлийн цэвэр

усны хамгамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэх, цэвэрлэсэн хаягдал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахад хувь нэмэр оруулна.

Зураг №11



Амгалан дулааны станц ТӨХК-ийн технологийн хэрэгцээнд М-СИ-ЭС КОКА-КОЛА ХХК-ийн үйлдвэрийн цэвэршүүлсэн хаягдал усыг дахин ашиглах төслийн нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

Зураг №12



Төслийн нээлтийн үйл ажиллагаанд ирсэн зочид бүтээн байгуулалттай танилцлаа.



#### **4.1. ЦЭВЭРШҮҮЛСЭН ХАЯГДАЛ УСЫГ БОЛОВСРУУЛЖ ДУЛААНЫ СТАНЦЫН НЭМЭЛТ УСНЫ ХЭРЭГЛЭЭГ ХАНГАХ СИСТЕМ**

**Технологийн зарчим:** М-Си-Эс Кока Кола ХХК-ийн үйлдвэрээс цэвэрлэсэн хаягдал усыг шугам хоолойгоор тээвэрлэн Амгалан дулааны станцын ус нөөцлөх бакуудад хуримтлуулан, дахин боловсруулж, дулааны эрчим хүч үйлдвэрлэх нэмэлт усны хэрэгцээнд ашиглана.

**Ашиглаж буй тоног төхөөрөмж:** М-Си-Эс Кока Кола ХХК-ийн үйлдвэрээс Амгалан дулааны станц хүртэлх HDPE маркийн Ду 280 мм-ийн голчтой 2,070 м-ийн урттай дан шугам, бохир усны 6 ширхэг худаг, тохируулах хаалт суурилуулах 1 ширхэг худаг, Ду 300 мм-ийн голчтой тохируулах фланцан хаалт 2 ширхэг, Ус нөөцлөх бак 400 м<sup>3</sup>-ийн 2 ширхэг, JMQ-2000 маркийн 60 м<sup>3</sup>/ц-ийн зарцуулалттай анионит филтер 3 ширхэг, 50 м<sup>3</sup>/ц-ын зарцуулалттай Sponge Iron деаэратор 1 ширхэг, дагалдах шугам хоолойн суурилуулалт, туршилт тохируулгын ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллагаанд оруулсан бөгөөд горим ажиллагаа хэвийн үргэлжилж байна.

**Шинэлэг байдал:** Амгалан дулааны станц нь нийслэлийн зүүн бүсийн дулаан хангамжийг найдвартай, тогтвортой хангахын зэрэгцээ усны нөөцийг хэмнэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор М-Си-Эс Кока Кола ХХК-ийн үйлдвэрийн цэвэршүүлсэн хаягдал усыг сүлжээний нэмэлт усны эх үүсвэр болгон ашиглах шинэчилсэн технологийн шийдлийг нэвтрүүлж байна. Энэхүү шийдэл нь Монгол Улсад дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн салбарт усны хэмнэлт, нөөцийн дахин ашиглалтыг цогцоор шийдсэн анхдагч жишээнүүдийн нэг бөгөөд дараах шинэлэг давуу талыг бий болгоно. Үүнд:

**1. Усны нөөцийн хомсдолыг бууруулсан шинэлэг шийдэл:** Улаанбаатар хотын гүний усны хэрэглээ өсөн нэмэгдэж буй нөхцөлд үйлдвэр, станцуудын үйлдвэрлэлийн усны хэрэглээг оновчтой болгох шаардлага нэмэгдэж байна. Амгалан дулааны станц нь гүний цэвэр усны хэрэглээг бууруулах зорилгоор өндөр түвшний боловсруулалттай хаягдал усыг сүлжээний нэмэлт ус болгон ашиглаж буй нь усны нөөц хамгааллын бодитой шинэ алхам болно.

**2. Хаягдал усыг эдийн засгийн эргэлтэд авчирсан загвар төсөл:** М-Си-Эс Кока Кола ХХК-ийн үйлдвэрийн цэвэршүүлсэн хаягдал ус нь олон шатлалт механик болон биохимийн боловсруулалтад орсон, тогтмол найрлагатай, дулааны станцын технологийн хэрэгцээнд тохирох шинж чанартай. Үүнийг ашигласнаар үйлдвэрийн хаягдал ус нөөц баялаг болон хувирч, хоёр байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурласан инновацын үр дүнтэй жишиг загвар бүрдэж байгаа юм.

**3. Байгаль орчинд үзүүлэх дарамтыг бууруулсан байгальд ээлтэй сонголт:** Бохирдлын дээд түвшний ариутгал, шүүлтүүрийн дамжлагад орсон хаягдал усыг дулааны станцад ашигласнаар:

- Гүний усны олборлолт тодорхой хувиар буурах
- Хаягдал усыг УСУГ-ийн бохирын системд нийлүүлэх хэмжээ багасах
- Хотын усны хэрэглээний дарамт буурах
- Ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн хаягдал багатай үйлдвэрлэл төлөвшиж байна.

Энэ нь дулааны станцын усны менежментэд “Эргэлтийн эдийн засгийн” зарчмыг бодитоор нэвтрүүлсэн инноваци юм.

Ингэснээр Амгалан дулааны станц ТӨХК нь төрийн өмчийн станцууд дундаа НОГООН ШИЙДЭЛ нэвтрүүлсэн анхны станц болж, Улаанбаатар хотын эрчим хүч, усны менежментийн салбарт шинэ шат ахисан түүхэн үйл явдал тохиож байна.

#### **4.2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРСЭН ХҮРСЭН ҮР ДҮН**

Цэвэршүүлсэн хаягдал усыг боловсруулж дулааны станцын нэмэлт усны хэрэглээг хангах системийг ашигласнаар байгаль орчны үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлт:

- Хэмнэгдэх эрчим хүч: 77,384.4 кВт.ц
- Хэмнэгдэх ус: 120,000 м<sup>3</sup>
- Бууруулах хүлэмжийн хий/агаар бохирдуулагч бодис: 92.86 тонн
- Бууруулах хог хаягдал: 120,000 м<sup>3</sup> ус
- Дахин ашигласан/боловсруулсан материал: 65.7 %

Эдийн засгийн үр ашиг:

- Төсөв, зардлын бууралт: авч ашигласан тн тутам 200 төгрөг хэмнэх
- Ашигт ажиллагааны өсөлт: 8.5 %
- Жилд хэмнэгдэж буй зардал: 41.5 сая төгрөг /боловсруулах болон цахилгааны зардлын хэмнэлт/

### 4.3. ТЕХНОЛОГИЙН УС БОЛОВСРУУЛАХ ТӨХӨӨРӨМЖ

Хаягдал ус ашиглах ажлын хүрээнд анионит шүүлтүүр 180 тн/цаг, хийгүйжүүлэх төхөөрөмж 50тн/цаг бүхий төхөөрөмж тус тус суурилуулсанаар үүсгэвэр усыг 2 удаагийн шүүлтүүрээр шүүж, усан дах шүлтийг бууруулан гарах усны чанарыг сайжруулах ач холбогдолтой.

Хүснэгт №53

Анионит шүүлтүүрийн техникийн үзүүлэлт			
№	Үзүүлэлт	Нэгж	Тоон утга
1	Анионит шүүлтүүр	ком	3
2	Ус боловсруулах хүчин чадал	Тн/цаг	60
3	Даралт	МПа	0,4-0,6
4	Шүүгдсэн усны үзүүлэлт	µS/cm	0,2

Хүснэгт №54

Хийгүйжүүлэх төхөөрөмжийн техникийн үзүүлэлт			
№	Үзүүлэлт	Нэгж	Тоон утга
1	Хийгүйжүүлэх төхөөрөмж	ком	1
2	Ус боловсруулах хүчин чадал	Тн/цаг	50-аас багагүй
3	Даралт	МПа	0,2-0,8
4	Гарах усны чанар	Мкг/л	50

400 м3-ийн багтаамжтай 2 ширхэг ус нөөцлөх бак

Зураг №14



Амгалан дулааны станц ТӨХК-ийн үйл ажиллагааны тайлан-2025 он

**50 м3/ц-ын зарцуулалттай 3 ширхэг анионит филтерийн насос**

Зураг №15



Зураг №16



## М-Си-Эс Кока Кола ХХК-ийн үйлдвэрийн цэвэршүүлсэн хаягдал усны трассын план

Зураг №17



### ТАВ. ТЕХНИК ХЯНАЛТ, ХАБЭА-Н ЧИГЛЭЛЭЭР

#### 5.1. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР

##### Наряд, шийдвэрээр гүйцэтгэх ажилд тавьсан хяналт

Станцын хэмжээнд наряд шийдвэрээр хийгдэж буй ажилд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт нарядын 320 ажил, шийдвэрээр гүйцэтгэсэн 465 ажилд хяналт тавьж ажилласан.

Хүснэгт №55

№	Галтай наряд	Тоо
1	Зуухан цех	129
2	Түлш дамжуулах цех	56
3	Засварын цех	2
4	Хими хэсэг	1
<b>НИЙТ</b>		<b>188</b>

#### Гэнэтийн ослын даатгал

ХАБЭА-н тухай хуулийн 28.4 дахь заалтийн хүрээнд Монгол даатгал ХХК –тай хамтран ажиллах гэрээ байгуулан өндөр эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа нийт 182 ажилтанг гэнэтийн ослын даатгалд хамруулан ажилласан ба дараах 1 ажилтны нөхөн төлбөрийн хүсэлт болон холбогдох материалуудыг бүрдүүлж нөхөн төлбөрийг олгуулсан.

**Амгалан дулааны станц ТӨХК-ийн үйл ажиллагааны тайлан-2025 он**

## **ISO 45001:2018 ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо**

Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ISO45001:2018 ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоог амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна. ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх ажлын хүрээнд нийт 8-н журам, 25-н процессын зураг боловсруулсан байна. Үүнд:

### **Дөрөвдүгээр бүлэг:**

1. 4.1 Байгууллагын төлөв байдлын судлагаа, шинжилгээ хийсэн.
2. 4.2 Сонирхогч талуудын судлагаа, шинжилгээ хийсэн.
3. 4.3 ХАБЭА-н МТ-ны хамрах хүрээ, бодлого тодорхойлсон.

### **Тавдугаар бүлэг:**

4. 5.1 Удирдлагын амлалт буюу Гүйцэтгэх захирал 10-н амлалт өгсөн.
5. 5.2 ХЭМАБ-н бодлогоо тодорхойлж нийт ажилтнуудад танилцуулсан.
6. 5.3 Ажлын байрны тодорхойлолтуудад ХАБЭА-н талаар нэмэлт өөрчлөлт оруулсан.
7. 5.4 ХАБЭА-н зөвлөлийн журамыг шинэчилэн болосруулсан.

### **Зургаадугаар бүлэг:**

8. 6.1 Хуулийн нийцэл хийж, өндөр эрсдэлтэй ажлын байрнуудад эрсдлийн үнэлгээ дахин шинэчилж хийсэн.
9. 6.1 Эрсдэл хяналтын журам боловсруулсан.
10. 6.2 ХАБЭА-н 2024 оны зорилт, төлөвлөгөөг боловсруулсан.

### **Долдугаар бүлэг:**

11. 7.2 Чадамжийн үнэлгээ ИТА нараас авч чадамжийг үнэлсэн.
12. 7.3 ХАБЭА-н сургалт зааварчилгааны журам боловсруулсан.
13. 7.4. Мэдээлэл харилцааны матриц боловсруулсан.
14. 7.5 Бичиг баримт боловсруулалт, хяналт бүртгэлийн журам

### **Наймдугаар бүлэг:**

15. 8.1 ХАБЭА-н хяналтын журам боловсруулсан.
16. 8.2 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилэгдсэн журмын дагуу шинэчилж батлуулсан.

### **Есдүгээр бүлэг:**

17. 9.1 Дотоод аудит хийх журам боловсруулсан.
18. 9.2 Дотоод аудит хийсэн.
19. 9.3 Удирдлагын дүн шинжилгээний хурал хийсэн.

### **Аравдугаар бүлэг:**

20. Аюултай тохиолдолыг судлан бүртгэх журам боловсруулсан.


2025 оны 12-р сарын 24, 25-ны өдрүүдэд МонСертф ХХК-ний баталгаажуулалтын аудитын баг амгалан дулааны станцын ажлын байр, үйлдвэрийн байранд шалгалт баталгаажуулалт хийсэн.

## **ХАБЭА-д хандах хандлагыг эерэг болгох, идэвхижүүлэх**

2025 оны 07-р сард Сүмбэр энтертаймент студийтай хамтран тус ажлыг нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй багаар хийж гүйцэтгэсэн. Reels /богино видео/ 2 хэсэгтэй аюулгүй ажиллагаа, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл болон нарядын системийг мөрдөж ажиллах

сэдвээр 1 мин 10 сек, 1 мин 28 сек видеог тус тус хийж нийт станцын ажилтнуудад танилцуулсан. Явцын ажлын гүйцэтгэлийг зургийг хавсаргав.

Зураг №18




### Зааварчилгаа

ХАБЭА-н тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.8 дахь заалт болон Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрмийн 12 дугаар бүлгийн дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгааг тухай бүрт өгч, хяналт тавьж ажилласан. Мөн 3 минут 32 секунд үргэлжилэх зочдын зааварчилгаа, 16 минут 41 секунд үргэлжилэх урьдчилсан зааварчилгааг видео хэлбэрээр танилцуулж ажиллаж байна.

Хүснэгт №56

№	Агуулга	Зааварчилгаа авсан ажилтан (Давхардсан тоогоор)
1	Урьдчилсан зааварчилгаа	261
2	Анхан шатны зааварчилгаа	42
3	Зочидын зааварчилгаа	344
4	Өдөр тутмын зааварчилгаа	14771
5	Сарын давтан зааварчилгаа	1458
6	Ээлжит бус зааварчилгаа	770
7	Тухайлсан зааварчилгаа	542
	Нийт	18138



### Мэдлэгийн шалгалт

Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны үндсэн дүрмийн 15-р бүлэгт заасны дагуу 2025 оны мэдлэгийн шалгалтыг 03.18-04.10-ны хооронд нийт 3 удаа зохион байгуулсан. Мэдлэгийн шалгалтын нийт 320 тест нэмж боловсруулан баяжуулалт хийгдсэн.

#### Үүнд:

1. ААД-ийн 3-р бүлгээс нийт 50 тест
2. ТАД-ийн 1.4-1.5, 3,4,5,6, -р бүлгээс нийт 100 тест
3. Зуухны ашиглалтын заавраас 50 тест
4. ЭХҮААНБДМГАБ-ын дүрмээс 50 тест
5. ТДЦех, Зуухан цех, Хими хэсгийн ашиглалтын заавруудаас тус бүр 50 тест
6. Анхны тусламжийн 20 тест

Жинхлэх болон зэрэг нэмэх шалгалтыг Сургалт, судлагааны мэргэжилтэнтэй хамтран тухай бүрт нь зохион байгуулж ажилласан.


#### Мэдлэгийн шалгалтанд хамрагдсан байдал:

Хүснэгт №57

№	Шалгалтын төрөл	Шалгалтанд хамрагдсан ажилтны тоо /давхардсан тоогоор/	
1	Ээлжит	167	
2	Жинхлэх	38	
3	Зэрэг нэмэх	23	
<b>Нийт</b>		<b>227</b>	
<b>Цех, хэсгээр хамрагдсан байдал</b>			
№	Цех, хэлтэс	Жинхлэх шалгалт /хүн/	Зэрэг нэмэх шалгалт /хүн/
1	Зуухан цех	13	11
2	ТДЦех	8	4

3	Засварын цех	4	4
4	Цахилгаан цех	6	4

График №36



### Мэдлэгийн шалгалт өгч буй байдал

Зураг №20



### Ажлын хувцас, гутал, хувийн хамгаалах хэрэгсэл

Нийт ажилтнуудад ажлын хувцас, гутал, хувийн хамгаалах хэрэгсэл олголтонд батлагдсан нормын дагуу олголт болон хэрэглээнд тогтмол хяналт тавьж, бүртгэл хөтлөж ажилласан. Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэлийн нормыг жил бүр шинэчилэн батлуулан ажиллаж байна.

**Амгалан дулааны станц ТӨХК-ийн үйл ажиллагааны тайлан-2025 он**

## Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл олгосон байдал

Зураг №58

№	Цех, нэгжийн нэр	Өвөл		Зун		Бомбор	С/цамц	Каск
		Хувцас	Гутал	Хувцас	Гутал			
1	Зуухан цех	22	22	21	21	36	13	16
2	ТДЦех	42	42	42	42	46	33	8
3	Цахилгаан цех	20	20	19	18	21	4	5
4	Засварын цех	10	9	12	8	24	12	6
5	АХММХэсэг	9	9	4	12	17	0	2
6	Хими хэсэг	7	2	8	9	15	1	0
7	Оффис	18	13	13	10	31	5	5
<b>Нийт</b>		<b>128</b>	<b>117</b>	<b>119</b>	<b>120</b>	<b>190</b>	<b>68</b>	<b>42</b>

## Эрүүл мэндийн үзлэг

“ХАБЭА-н тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 болон Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10-р сарын 20-ний өдөр батлагдсан А/340 тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”-ийн дагуу нийт ажилтнуудыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулах ажлыг “Хэлт рөүд”ХХК-н Клинико эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу 2025 оны 08-р сарын 01-ний өдрөөс 11-р сарын 01-ний хооронд зохион байгуулсан. Эрүүл мэндийн хугацаат 3 багц үзлэгт нийт 190 ажилтан хамрагдсан.

Хүснэгт №59

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙН ТАЙЛАН		
1	Нийт ажилны тоо	212
2	Эрүүл мэндийн үзлэгт орох ажилтнуудын тоо	190
3	Эрэгтэй	145
	Эмэгтэй	45
4	Эрүүл мэндийн хугацаат үзлэгт орсон ажилтнуудын тоо	190
5	Эрүүл мэндийн хугацаат үзлэгийн хамрагдалтын хувь	89.6%
6	Эрүүл мэндийн хувьд тэнцсэн ажилтнуудын тоо	190
7	Түр хугацаагаар эрүүл мэндийн үзлэгт тэнцээгүй ажилтнуудын тоо	0
8	Эрүүл мэндийн хувьд тэнцээгүй ажилтнуудын тоо	0
9	Мэргэжлээс шалтгаалсан өвчний асуудал эрхэлсэн төв байгууллагад илгээж онош тодруулах шаардлагатай ажилтнуудын тоо	0
10	Амбулаториор онош тодруулж, эмчлүүлэх шаардлагатай ажилтнуудын тоо	10
11	Стационарт онош тодруулах, хэвтэн эмчлүүлэх шаардлагатай ажилтнуудын тоо	0
12	Сувилалд эмчлүүлэх шаардлагатай ажилтнуудын тоо	0

**ДҮГНЭЛТ:**

Нийт 190 ажилтан эмчийн үзлэгт хамрагдсан ба эмнэлзүй болон хийгдсэн шинжилгээнүүдэд тулгуурлан дотор эрхтний эмгэгийн урьдчилсан онош тавихад давхардсан тоогоор хоол боловсруулах эрхтний эмгэг 241, дотоод шүүрэл бодисын солилцооны эмгэг 81 давамгайлж байна. Онош тус бүрээр авч үзвэл хеликобактерийн халдвар 99, нойр булчирхайн архаг үрэвсэл 34, элэгний өөхжилт 47, синусын брадикарди 30 давамгайлж байна.

**Албан шаардлага, мэдэгдэх хуудас**

Ажлын байрны эргэлт, шалгалтыг тогтмол хийж, үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулах арга хэмжээ авч ажилласан.

**Албан шаардлага**

Хүснэгт№60

№	Цех, нэгж	Дугаар	Албан даалгавар	Биелэлт
1	Зуухан цех	01	Үнсний шугамын цоорч байгаад арга хэмжээ авах	100%
2	Цахилгаан цех, Зуухан цех	02	Хянах хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдал	100%
3	Зуухан цех	03	Вагон гэсгээгчийн шугамд хаалт арматур суурилуулах	100%
4	Зуухан цех	04	ТАД-н дүрмээр сургалт орох	100%
5	Цахилгаан цех	05	ТАД-н дүрмээр сургалт орох	100%
6	Засварын цех, Цахилгаан цех	06	ХХБ-ийг ус чийгнээс тусгаарлах	100%
7	Цахилгаан цех	07	Өндөржүүлсэн бэлэн байдалтай холбоотой харилцаа холбооны найдвартай байдлыг хангах	100%
8	ТДЦех	08	Нүүрсний ширхэгжилтийг стандарт хэмжээнд барих	0
9	Эрчим дөл ХХК	09	Зуух №3-н засварын ажил гүйцэтгэхдээ ХАБЭА болон ГАБ мөрдөж ажиллах	100
<b>Нийт</b>				<b>90%</b>

**Мэдэгдэх хуудас**

Хүснэгт№61

№	Цех, нэгж	Дугаар	Албан даалгавар	Биелэлт
1	Зуухан цех	01	Компрессор №4-ийн доргиог зөвшөөрөгдөх хэмжээнд барих	100%
2	Зуухан цех	02	Ажлын байрны цэвэрлэгээг чанаржуулах /0 болон 8-р тэмдэгт/	100%
3	Зуухан цех	03	Барилгын хана, цонхны тавцан, дээвэр болон тоноглолын гадаргуу дээрх нарийн тоос тоосонцорыг цэвэрлэх	0%
4	Цахилгаан цех	04	Хариуцсан тоноглолын гадаргуу дээрх нарийн тоос тоосонцорыг цэвэрлэх	0%
<b>Нийт</b>				<b>50%</b>

### Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд MNS 5080:2023 стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-н 28 ажлын байрны эрсдэлд суурилсан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний хэмжилт судалгаа, шинжилгээ хийлгэсэн. Хяналтын хэмжилтээр 4 ажлын байр эрүүл мэндийн өндөр эрсдэлтэй гарсан. Үүнд:

1. Зуухан цехийн ашиглалтын инженер
2. Зуухан цехийн ээлжийн дарга
3. Тоног төхөөрөмжийн засварчин
4. Сорьц бэлтгэгч

Мөн 24 ажлын байр дунд зэргийн эрсдэлтэй гэж тус тус тодорхойлогдсон.

Зураг №21



### Сургалт, дасгал

Шинэ ажилтаны батлагдсан хөтөлбөрийн дагуу 7 хоног бүр шинэ ажилтны сургалтыг зохион байгуулж нийт 27 ажилтанд 7 бүлэг дэд сэдвээр мэдлэг олгож хамруулсан.

*Сургалтанд хамрагдсан байдал:*

Хүснэгт №62

№	Сургалтын нэр	Сургалтанд хамрагдсан ажилтан
1	Ажил олгогч, удирдах ажилтны сургалт	15
2	Нийт ажилтны сургалт	171
3	Шинэ ажилтны сургалт	27
4	Галын дохиоллын сургалт	20
Нийт		233

## Удирдах ажилтны сургалт

Зураг №22



## Нийт ажилтны сургалт

Зураг №23



## Аваари, гал эсэргүүцэх дасгал

Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны үндсэн дүрмийн 14.2, 14.3 дахь заалтын дагуу үйлдвэрлэлийн бодлого, шуурхай ажиллагаагны хэлтэстэй хамтран Амгалан дулааны станц ТӨХК-ийн Ашиглалтын 2-р ээлжийн 23 ажилтан Нэгдсэн сүлжээний аваар эсэргүүцэх дасгалыг ажлын байран дээр 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 09 цагт зохион байгуулсан. Системийн аваари эсэргүүцэх дасгалд шинээр ажилд орсон болон ажлын байрнаас хөндийрсэн 22 ажилтанг хамрагдсан.


Засварын цех 2025 оны 03-р сарын 24-ний өдөр станцын талбайд гал эсэргүүцэх дасгалыг амжилттай зохион байгуулж нийт 10 ажилтныг хамруулсан.

